



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ 2015 ОН

2015 оны Эрүүл Мэндийн салбарын **ТЭРГҮҮНИЙ** байгууллагаар шалгарсан Нийслэлийн Эрүүл Мэндийн газраас эрхлэн гаргав.

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газар

Шуудангийн хаяг: 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3, Жигжиджавын гудамж, Хангарди ордон 9 давхарт

Энэхүү эмхэтгэлийн талаархи саналыг дараах хаягаар ирүүлнэ үү.

Утас: 329114

Э- шуудан: Info@ubhealth.mn , nemg_statistik2014@yahoo.com

Веб сайт: <http://www.emg.ub.gov.mn>

Эрхэлсэн : Ш.Энхбат, НЗДХА - Эрүүл мэндийн газрын дарга

Хянасан: С.Ариунтуяа, СХШХ-ийн дарга

Эмхэтгэсэн: А.Оюунгэрэл, СХШХ-ийн мэдээллийн мэргэжилтэн
Г.Дэлгэрсүрэн, СХШХ-ийн мэдээллийн мэргэжилтэн
Б.Сэргэлэн, СХШХ-ийн мэдээллийн мэргэжилтэн
Ш.Мөнхзул, СХШХ-ийн мэдээллийн мэргэжилтэн
Т.Хонгорзул, ТСХОХ-ийн мэргэжилтэн

ӨМНӨХ ҮГ

Нийслэлийн эрүүл мэндийн газар нь нь 2005 оноос эхлэн жил бүр эрүүл мэндийн байгууллагуудын албан ёсны статистик мэдээ, тайланд тулгуурлан, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийг олон улсын аргачлалын дагуу тооцож, боловсруулалт хийж, эмхэтгэн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, эмнэлгийн ажилтан эмч нарт хүртээл болгож байгаа билээ.

Энэхүү 2015 оны эмхэтгэлд Монгол улсын хүн ам зүйн үндсэн үзүүлэлт, Мянганы хөгжлийн зорилтын эрүүл мэндийн үзүүлэлт, улсын хэмжээнд эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмч эмнэлгийн мэргэжилтнүүд, эмнэлгийн тусламж үйлчилгээний үзүүлэлт болон нийслэлийн хүн амын эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт, хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан, нийслэлийн эрүүл мэндийн салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтын үндсэн үзүүлэлтийг нэгтгэн, дүн шинжилгээ хийж нийт 68 хүснэгт, 91 график дүрслэлээр илэрхийлэн орууллаа.

Монгол улс Мянганы хөгжлийн зорилтыг амжилттай хэрэгжүүлсэн дэлхийн 9 орны тоонд орсон. Эх хүүхдийн эндэгдлийг бууруулах, ХДХВ/ДОХ, сүрьеэ өвчинтэй тэмцэх гэсэн ЭМ-ийн зорилтуудын хүрээнд эхийн эндэгдэл 2015 онд 28.7 болж 1990 оны түвшинтэй харьцуулахад 4.4 дахин, нялхсын эндэгдлийн түвшин 17.8 болж 5.6 дахин, Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 17.3 болж 4.8 дахин тус тус буурсан үзүүлэлттэй байна. Монгол улсын хүн амын 45.7 хувь нь нийслэл Улаанбаатар хотод амьдарч, нийт төрөлтийн 50 гаруй хувийг эзэлж буй нийслэлийн хүн амын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнг илтгэх чухал үзүүлэлт болох нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл тогтвортой буурч, сүүлийн 10 жилийн үзүүлэлтээр улсын дундаж үзүүлэлтээс бага байна.

2015 онд салбарын хэмжээнд эрүүл мэндийн анхан шатны тусламжийн хүртээмжийг тэргүүлэх чиглэл болгосонтой холбоотойгоор нийслэлийн 142 Өрхийн эрүүл мэндийн төвийг НЭМГ-ын хамтын ажиллагааны хүрээнд шээсний орчин үеийн оношлогооны аппаратаар хангаснаар тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад томоохон ахиц гаргасан.

Нийслэлийн хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтийн эмхэтгэлийг 2014 оноос англи хэлээр орчуулан гаргасан нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах харилцааг тэлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал алхам болсон.

Нийслэлийн хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж буй харьяа эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөц, амбулатори стационарын тусламж үйлчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, хүн амын өвчлөл, нас баралтын бодит тоон эмхэтгэл 4 боть номыг анх удаа эмхэтгэн гаргаж эрдэмтэн судлаач, эрүүл мэндийн салбарын нийт эмч, удирдлага, хэрэглэгчдэд зориулан гаргалаа.

Улаанбаатар хотын хүн амын эрүүл мэндийн статистик үзүүлэлтийн сар, улирал, жилийн мэдээллийг манай цахим хуудас болох www.emg.ub.gov.mn-д хандан хэрэглэгч Та шаардлагатай мэдээллээ авах боломжтой.

Энэхүү эмхэтгэл нь бүх түвшний эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтнууд болон бусад мэдээлэл хэрэглэгчдэд нотолгоонд тулгуурласан оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлнэ гэдэгт найдаж байна.

ДАРГА



Ш.ЭНХБАТ /Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор/

ГАРЧИГ

Бүлэг I. ХҮН АМ

- 1.1. Хүн ам (Улаанбаатар хотын хүн ам)
- 1.2. Хүн ам зүйн үндсэн үзүүлэлт

Бүлэг II. МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗОРИЛТУУД

Бүлэг III. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

- 3.1. Жирэмсний хяналт ба төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ
- 3.2. Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ
- 3.3. Төрсний дараах үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ
- 3.4. Эхийн эндэгдэл
- 3.5. Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга, хэрэглээ
- 3.6. Үр хөндөлт
- 3.7. Хүүхдийн эрүүл мэнд
- 3.8. Нялхас болон 5 хүртэлх насны хүүхэд, өсвөр насны хүүхдийн эндэгдэл
- 3.9. Хүүхэд, өсвөр үеийнхний өвчлөл

Бүлэг IV. ХАЛДВАРТ ӨВЧИН

- 4.1. Цочмог халдварт өвчин
- 4.2. Бэлгийн замаар дамжих халдвар
- 4.3. Гэдэсний халдвар
- 4.4. Амьсгалын замын халдвар

Бүлэг V. ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

- 5.1. Хүн амын нийт өвчлөл
- 5.2. Хорт хавдрын өвчлөл
- 5.3. Халдварт бус өвчний эрт илрүүлэг
- 5.4. Стационарын тусламж үйлчилгээ

Бүлэг VI. ХҮН АМЫН НАС БАРАЛТ

Бүлэг VII. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

- 7.1. Өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээ
- 7.2. Дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээ
- 7.3. Амбулатори, поликлиникийн тусламж үйлчилгээ
- 7.4. Хувийн эмнэлгийн тусламж үйлчилгээ
- 7.5. Яаралтай түргэн тусламж, үйлчилгээ
- 7.6. Настны эрүүл мэнд
- 7.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд
- 7.8. Сэтгэцийн эрүүл мэнд

- Бүлэг VIII. НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ХҮНИЙ НӨӨЦ
- Бүлэг IX. НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ
- Бүлэг X. ДҮҮРГҮҮДИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХБ	Азийн хөгжлийн банк
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ВХА	Вирүст хепатит А
ВХВ	Вирүст хепатит В
ВХС	Вирүст хепатит С
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ДОТС	Шууд хяналттай богино хугацааны эмчилгээ
ЖСА	Жирэмслэлтээс сэргийлэх арга
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
НБЕК	Нас баралтын ерөнхий коэффициент
НЭМ	Нийгмийн эрүүл мэнд
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НД	Налайх дүүрэг
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
ОЭТС	Олон эмэнд тэсвэртэй сүрьеэ
ӨОУА	Өвчний олон улсын ангилал
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТЕК	Төрөлтийн ерөнхий коэффициент
ТНК	Төрөлтийн нийлбэр коэффициент
ТТК	Төрөлтийн тусгай коэффициент
УБ	Улаанбаатар
УНТЭ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
УХТЭ	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
УГТЭ	Улсын гуравдугаар төв эмнэлэг
ХУД	Хан Уул дүүрэг
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХСҮТ	Хавдар судлалын үндэсний төв
ХДХВ	Хүний дархлал хомсдлын вирүс
ХХЭМБ	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭМСЯ	Эрүүл мэнд спортын яам
ЭХЭМҮТ	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМАШТ	Эрүүл мэндийн анхан шатны тусламж
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

ХУРААНГУЙ ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Монгол Улс	Улаанбаатар хот
Хүн ам		
Нийт	3 057.7	1 345.5*
Үүнээс: эрэгтэйчүүдийн эзлэх хувь	49.2	48.4
эмэгтэйчүүдийн эзлэх хувь	50.8	51.6
ТЕК	26.7	32.1
ТНК	3.1	2.7
НБЕК	5.4	5.6
Цэвэр өсөлт	2.1	2.6
Дундаж наслалт	69.9	71.8
МХЗ, Эх хүүхдийн эрүүл мэнд		
Төрсөн эх	80434	41447
Амьд төрсөн хүүхэд	80875	41731
Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд	26.0	28.8
Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин	15.3	14.7
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин	18.3	17.3
Амьгүй төрөлтийн түвшин	6.8	7.8
Жирэмсний эрт хяналтын хувь	84.2	84.1
20 хүртэлх насны охидын төрөлтийн хувь	5.5	4.9
Эмнэлгийн тусламж үйлчилгээ		
Нийт үзлэг	16 620 444	8 268 570**
Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	32.3	36.2**
Гэрийн идэвхитэй хяналтын үзлэгийн хувь	10.9	13.9**
Нэг хүртэлх насны хүүхдийн хяналтын хувь	88.4	93.8**
Нэг иргэн жилд дунджаар үзүүлсэн удаа	5.4	6.4**
Стационарын тусламж үйлчилгээ		
Эмчлэгдсэн өвчтөн	787834	242519.5**
Орны тоо	21720	6056**
Дундаж ор хоног	7.3	6.6**
Орны эргэлт	36.3	40.1**
Эмнэлгийн нас баралтын хувь	3748	0.23**
Хоног болоогүй нас баралтын хувь	878	28.9**
Фонд ашиглалт	80.6	79.7**
Хүний нөөц		
10000 хүн ам ногдох эмч	31.6	40.9
10000 хүн амд ногдох сувилагч	37.5	40.8
10000 хүн ам ногдох эмнэлгийн мэргэжилтэн	24.5	17.5
Эмч/сувилагчийн харьцаа	1:1.2	1:1.1
Нэг эмчид ногдох хүний тоо	316	237
Эрүүл мэндийн байгууллага		
Нийт ЭМБ	3244	1475**
Үүнээс: ӨЭМТ	218	129**
Тосгоны эрүүл мэндийн төв	19	5**
ХХЭМБ	2545	1300**

* Суурин хүн амын тоо

**НЭМГ-ын харьяа ЭМБ-ын үзүүлэлт

Бүлэг I. ХҮН АМ

1.1. ХҮН АМ

Монгол улсын хүн ам 2015 оны жилийн эцсийн байдлаар 3 сая 57.7 мянга болж, өмнөх оноос 61.8 мянган хүнээр буюу 2.1 хувиар өслөө. Нийт хүн амын 68.0 хувь нь хот суурин газар, 32.0 хувь нь хөдөө амьдарч байна.

Нийт хүн амын 49.2 хувийг эрэгтэйчүүд, 50.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа ба хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрчүүдийн тоо 97 байна. 2015 оны байдлаар 859.1 мянган өрх амьдарч байгаа ба дунджаар 1 өрхөд 3.5 хүн ногдож байна.

Улаанбаатар хотод нийт хүн амын 45.7 хувь нь оршин сууж байна. 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар Улаанбаатар хотын суурин 1.345.5 хүн ам 9 дүүрэгт оршин сууж байгаа ба өмнөх оноос 31.1 мянган хүнээр буюу 2.3 хувиар өслөө.


Нийслэлийн хүн амын 48.4 хувийг эрэгтэйчүүд, 51.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа ба хүйсийн харьцаа 100 эмэгтэйд 94 эрэгтэй ногдож байна.

Насны бүтцийн хувьд авч үзвэл 15 хүртэлх насны хүүхэд 29.7 хувийг, 15-19 насны хүүхэд 6.7 хувийг, 20-64 насны хүн ам 59.7 хувийг, 65 дээш насны хүн ам 3.8 хувийг тус тус эзэлж байна.


Улаанбаатар хотод 100-аас дээш настай 46 өндөр настан амьдарч байгаагаас 21.7 хувь нь эрэгтэй, 78.3 хувийг эмэгтэй ахмад настан эзэлж байна.

2015 оны байдлаар нийслэлд 376.4 мянган өрх амьдарч байгаа ба дунджаар 1 өрхөд 3.6 хүн ногдож байна.

Зураг 1.1.1. Улаанбаатар хотын суурин хүн ам, дүүргээр, 2015 он



Зураг 1.1.2. Улаанбаатар хотын дундаж хүн ам, дүүргээр, 2015 он



Эх сурвалж: Нийслэлийн статистикийн газар


1.2. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ, ДУНДАЖ НАСЛАЛТ

Монгол Улсын Засгийн газраас хүн амын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогыг тодорхойлон төрөлтийг дэмжих бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлсний дүнд сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдэж байна.

1990 онд 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин 35.3 байсан бол 2005 онд 17.8 болж 2 дахин буурч хамгийн бага түвшинд хүрсэн бөгөөд 2006 оноос тогтвортой нэмэгдэн 2015 онд 26.7 болсон байна. Хүн амын цэвэр өсөлт 1990 онд 2.7 байсан бол 2010 онд 1.7 болон буурч, 2011 оноос тогтвортой нэмэгдэн 2015 онд 2.1 болсон байна. Хүн амын дундаж наслалт 69.9 байна.

Улаанбаатар хотод 1000 хүн амд ногдох төрөлт 1996-2005 онуудад тогтвортой түвшинд байж байгаад 2006 оноос нэмэгдсээр 2015 онд 32.1 болсон нь сүүлийн жилийн дундаж үзүүлэлтээс 1000 хүн ам тутамд 3.3-аар нэмэгдсэн байна.

Зураг 1.2.1. Хүн ам зүйн үзүүлэлтүүд, сүүлийн 10 жилээр



Хүн амын төрөлт нэмэгдэж байгаатай холбоотой сүүлийн жилүүдэд цэвэр өсөлт хоёр дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 1.2.1. Хүн ам зүйн үндсэн үзүүлэлт, сонгосон онуудаар

Он	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Насны бүлгээр /хувиар/										
Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	51.71	51.75	51.84	51.89	52.69	52.66	52.65	52.41	52.24	51.6
0-15нас	25.78	26.67	26.23	25.31	25.09	25.07	27.59	26.79	26.82	29.7
16-64нас	69.78	69.12	69.48	70.5	70.96	70.86	68.35	69.27	69.13	66.4
65-аас дээш	4.44	4.21	4.29	4.2	3.94	4.05	4.05	3.92	4.03	3.8
Хүн ам зүйн коэффициентууд										
ТЕК	20.88	24.3	26.86	29.07	27.84	29.73	31.26	32.79	33.22	32.11
НБЕК	6.63	6.65	6.09	5.97	6.75	6.17	6.49	6.12	6.00	5.60
Цэвэр өсөлт	14.2	17.6	20.77	23.1	21.09	23.56	24.77	26.67	27.22	26.51

Төрөлтөөс тооцсон дундаж наслалт нь хүний хөгжлийн индексийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд 2015 оны байдлаар Монгол улсын хүн амын дундаж наслалт нь 69.9 болж өмнөх оноос 0.3-аар, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 0.6-аар, эрэгтэйчүүдийн дундаж наслалт 0.5-аар тус тус нэмэгдсэн байна.

Улаанбаатар хотын хүн амын дундаж наслалт 71.8, үүнээс эрэгтэйчүүдийн дундаж наслалт 66.5, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.3 байгаа нь эрэгтэйчүүдийн амьдрах хугацаа, эмэгтэйчүүдийнхээс 8.8 жилээр бага байна.

Дундаж наслалтын хувьд хүйсийн ялгаа аль ч улс оронд байдаг ба эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс дунджаар 4 насаар илүү бөгөөд манай улсын хувьд 9.8 жилээр, Улаанбаатар хотын хувьд 8.8 жилээр илүү байна.

Хүснэгт 1.2.2. Хүн амын дундаж наслалт бүсээр, хүйсээр, 2015 он


Аймаг, хот	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Баруун бүс	70.7	66.8	74.1
Баян-Өлгий	73.3	69.9	75.8
Говь-Алтай	69.4	64.4	73.0
Завхан	69.7	67.2	72.5
Увс	68.8	63.9	72.9
Ховд	12.3	68.7	76.2
Хангайн бүс	70.1	67.2	74.2
Архангай	71.1	68.5	72.7
Баянхонгор	69.4	66.0	71.3
Булган	72.9	68.2	76.0
Өвөрхангай	69.9	67.2	72.8
Хөвсгөл	66.3	63.2	71.2
Орхон	71.4	70.3	80.9
Төвийн бүс	72.0	68.5	76.2
Говьсүмбэр	73.4	71.9	76.1
Дархан-Уул	69.0	64.7	73.9
Дорноговь	70.7	66.0	76.0
Дундговь	73.8	70.6	78.6
Өмнөговь	72.0	68.1	75.4
Сэлэнгэ	72.4	68.1	77.8
Төв	72.6	70.3	75.7
Зүүн бүс	70.9	67.0	75.0
Дорнод	68.9	64.9	73.4
Сүхбаатар	72.3	67.3	76.4
Хэнтий	71.5	68.7	75.1
Улаанбаатар	71.8	66.5	75.3
Улс	69.9	75.8	66.0

Аливаа улсын хүн амын дотор залуу насны хүн амын эзлэх хувь их байвал хүн ам зүйн шинжлэх ухаанд залуу хүн амтай улс гэж үздэг. Ихэнх хөгжиж байгаа орнуудад хүн амын бараг хагас нь 15-аас доош насныхан, 10-15 орчим хувь нь 65 буюу түүнээс дээш насныхан байдаг. Манай орны хувьд 2015 оны байдлаар 15-аас доош насныхан 29.6 хувь, 65 буюу түүнээс дээш насныхан 3.8 хувийг эзэлж байгаа бол Улаанбаатар хотын хувьд 15-аас доош насныхан 29.7 хувь, 65 буюу түүнээс дээш насныхан 3.8 хувийг эзэлж байна.


Хүн амын нас хүйсийн суварга нь цаг хугацааны тодорхой үеийн хүн амын нөхөн үржихүйн тасралтгүй процессийн явцыг харуулна. Хэрэв хүн амын нөхөн үржихүйн процессийн тухайлбал төрөлт, нас баралтын түвшинд ямар нэг өөрчлөлт гараагүй тохиолдолд насны суварга нь тэнцүүхэн дүрслэгдэх ба урт хугацааны туршид төрөлтийн өндөр түвшин хадгалагдаж, нас баралтын түвшин ч харьцангуй өндөр байсан тохиолдолд суваргын суурь нь өргөн, орой руугаа нарийссан хэлбэртэй, харин төрөлт, нас баралтын түвшин бага байсан тохиолдолд суурь нь нарийхан, орой руугаа өргөссөн хэлбэртэй байна.

Зураг 1.2.2.

Нас, хүйсийн суварга, 2005 он



Нас, хүйсийн суварга 2015 он



2005 болон 2015 оны хүн амын нас, хүйсийн суваргыг харьцуулахад 2005 онд харьцангуй пирамид хэлбэртэй байхад 2015 оны суварга нь дунд хэсгээрээ аажмаар өргөсч байгаа нь Улаанбаатар хотын хүн амын дийлэнх нь идэр насны хүн ам эзэлж, хөдөлмөрийн насны хүн ам нэмэгдэж хүн ам зүйн цонх үе үргэлжлэхийг харуулж байна. Сүүлийн жилүүдэд төрөлт тогтвортой нэмэгдэж 0-4 насны хүн ам их байгаа нь суурь өргөн бүтэцтэй байгааг харуулж байна.

Бүлэг II. МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Мянганы Хөгжлийн Зорилтыг 2000 оны 9 сард дэлхийн мянганы дээд хэмжээний чуулга уулзалтаар тогтвортой хөгжил, ядууралтай тэмцэх асуудлыг дэлхийн хөгжлийн тэргүүлэх чиглэлээр сонгосноор мянганы хөгжлийн зорилтууд нь аль ч улс орны хөгжил дэвшлийг хэмжих хэмжүүр болж байна. Монгол улс Мянганы хөгжлийн зорилтыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг улс орны нийгэм, эдийн засгийн нийтлэг болон өвөрмөц онцлогийг харгалзан үзэж 2008 оноос Мянганы хөгжлийн зорилтыг баяжуулан өргөжүүлж шинэчлэн гаргасан. 2015 онд Дэлхийн улс орнуудын МХЗ-ын хэрэгжилтийг дүгнэж, Монгол улс амжилттай хэрэгжүүлсэн дэлхийн 9 орны тоонд багтсан.

Зорилт 9. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах

Монгол Улсын Засгийн газраас нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулахад онцгой анхаарч 1990 оноос 2015 он гэхэд 4 дахин бууруулах зорилт дэвшүүлсэн.

1990 онд 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 99.9, нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 70.3 байсан бол 2006 онд 21.8 болон 19.0 болж 2015 онд хүрэхээр тавьсан зорилтоо хангахуйц болсон тул 2008 онд Монгол Улсын Засгийн Газраас хүрсэн амжилтаа бататгахын тулд 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 21.0, нялхсын эндэгдлийг 15.0-д хүргэх шинэ зорилтуудыг дэвшүүлсэн юм.

Хүснэгт 2.1. Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, сонгосон онуудаар

Үзүүлэлт	1990	2000	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	99.9	42.4	18.1	21.8	18.8	20.8	21.0	20.6	16.2	16.0	16.3	17.8	17.3
Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	70.3	32.8	21.7	19	14.7	17.5	18.0	16.1	13.3	13.1	13.6	14.9	14.7

Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 оноос хойшхи 20 жилийн хугацаанд эрчимтэй буурч 2015 онд 1000 амьд төрөлтөд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 17.3 байгаа нь 1990 оны түвшинтэй харьцуулахад 5.8 дахин, нялхсын эндэгдлийн түвшин 4.7 дахин буурсан. 2014 онтой харьцуулахад тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 0.5, нялхсын эндэгдэл 0.2-оор тус тус буурсан байна.

Зорилт 10. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг зохих насны хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд дөрөв дахин бууруулах

Монгол улс эхийн эндэгдлийн түвшингээр бүсийн болон өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулахад дунд зэргийн орны тоонд багтдаг билээ. Эхийн эндэгдлийг бууруулах талаар Засгийн газраас ихээхэн анхаардаг төдийгүй энэ талаар хэрэгжүүлдэг хөтөлбөр, төсөл, стратегиуд амжилттай хэрэгжсээр байна.


Манай улс 1996 оны эхийн эндэгдлийн түвшинг суурь үзүүлэлт болгон ашиглаж 2015 он гэхэд эхийн эндэгдлийг 100 000 амьд төрөлтөд 50.0 болгох зорилтыг дэвшүүлсэн ба 2015 онд эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд 26.0 болж зорилтоо хэрэгжүүлсэн нэг шалгуур болсон.

Хүснэгт 2.2. Эхийн эндэгдлийн түвшин, 100 000 амьд төрөлтөд, сонгосон онуудаар

Үзүүлэлт	1996	2000	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Эхийн эндэгдлийн түвшин/100 000 амьд төрөлтөд/	97.7	171.1	73.3	71.8	73.7	55.2	78.9	46.2	44.2	43.0	52.3	35.9	28.8
Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь	97.5	99.7	99.5	99.7	99.6	99.4	99.8	99.5	99.7	99.8	99.8	99.8	99.8

Улаанбаатар хотод сүүлийн 10 жилийн хугацаанд эхийн эндэгдэл тогтвортой буурч 2015 онд эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд 28.8 болж 1996 оны түвшнээс 3.4 дахин, өмнөх оноос 7.1 промилиор буурч 20 жилийн хамгийн доод түвшинд хүрсэн байна.

Зураг 2.1. Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд



Зорилт 11. 2015 он гэхэд ХДХВ/ДОХ өвчний тархалтыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх

Манай улсын нийт хүн амын дунд Хүний дархлал хомсдлын вирусийн халдварын тархалтын түвшин 0.1 хувиас бага, эрсдэлт бүлгийн хүн амын дунд 5.0 хувиас бага байгаа нь нийт хүн амын дунд бага, эрсдэлт бүлгийн хүн амын дунд төвлөрсөн тархалттай орны тоонд орж байна.

1992 онд Монгол улсад ХДХВ/ДОХ-ын анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш 2015 оны жилийн эцсийн байдлаар ХДХВ/ДОХ-ын нийт 199 тохиолдол бүртгэгдэж, үүнээс 18 тохиолдол нь 2015 онд шинээр бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн 199 тохиолдлын 27 (13.5 хувь) нь нас барсан байна. Нийт тохиолдлыг хүйсээр авч үзэхэд: 159 нь (79.9 хувь) эрэгтэйчүүд, 39 нь (19.6 хувь) эмэгтэйчүүд, хүйс тодорхойгүй 1 (0.5 хувь) хүн байна.

Бүртгэгдсэн ХДХВ-ийн халдвар зонхилон бэлгийн замаар дамжсан байна. Цус, цусан бүтээгдэхүүн, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын тохиолдол, мөн эхээс хүүхдэд халдвар дамжсан тохиолдол бүртгэгдээгүй байна.

Хүснэгт 2.3. Жирэмсэн эмэгтэйчүүд болон 15-24 насны залуучуудын дундах ХДХВ-ийн тархалт, хувиар

Шалгуур үзүүлэлт	1990	2000	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах ХДХВ-ын халдварын тархалт	-	-	0.004	0.001	0.0	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1
15-24 насны залуучуудын дундах ХДХВ-ын халдварын тархалт	-	-		0.0007	0.0005	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1

2015 онд шинээр бүртгэгдсэн ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн 12 нь (66.7 хувь) эрэгтэйчүүд, 6 нь (33.3 хувь) эмэгтэйчүүд байна. 13 буюу 72.2 хувь нь УБ хотоос, 5 буюу 27.8 хувь нь хөдөө орон нутгаас оношлогдсон байна.

Насны бүлгээр авч үзвэл: 20-24 насанд 16.7 хувь буюу 3 тохиолдол, 25-29 насанд 16.7 хувь буюу 3 тохиолдол, 30-34 насанд 27.8 хувь буюу 5 тохиолдол, 35-39 насанд 16.7 хувь буюу 3 тохиолдол, 45-49 насанд 11.1 хувь буюу 2 тохиолдол, 50-аас дээш насанд 11.1 хувь буюу 2 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Зорилт 12. 2015 он гэхэд сүрьеэ өвчний тархалтыг зогсоож, бууруулах

Монгол улс 1996 оноос шууд хяналттай богино хугацааны эмчилгээний стратеги (ДОТС)-ийг нэвтрүүлснээр 2007 оноос буурах хандлага ажиглагдаж байгаа хэдий ч 2015 онд дэвшүүлсэн зорилтыг хангахад боломжгүй байгаа юм. 2015 он гэхэд 100 000 хүн амд ногдох сүрьеэгийн өвчлөлийг 100, нас баралтыг 2.0 хүртэл бууруулах, ДОТС-ийн хүрээнд эмчилсэн сүрьеэгийн тохиолдлын хувийг 100-д хүргэх зорилтууд дэвшүүлсэн.

Улсын хэмжээнд 2015 оны байдлаар 4270 сүрьеэгийн шинэ тохиолдол бүртгэгдэж Улаанбаатар хотод 2534 тохиолдол буюу 59.3 хувь нь бүртгэгдсэн байна.


10 000 хүн амд ногдох өвчлөлөөр Сонгинохайрхан дүүрэг 20.7, Хан Уул 19.8, Чингэлтэй 21.1, Багахангай дүүрэг 28.5 байгаа ба улс болон УБ-ын дунджаас өндөр байна.

Зураг 2.2. Сүрьеэгийн өвчлөл, 10000 хүн амд, дүүргээр, 2014-2015 он




Шинээр илэрсэн сүрьеэтэй өвчтөний 68.0 хувийг 15-44 насныхан эзэлж байгаа нь залуу хөдөлмөрийн насны хүмүүс илүүтэй өвчилж байгааг харуулж байна. Хүйсийн хувьд 54.9 хувийг эрэгтэйчүүд, 45.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Нийт өвчлөл дотор уушгины сүрьеэ 2361 (55.3%), уушгины бус эрхтний сүрьеэ 1909 (44.7%) бүртгэгдсэнийг 2014 оны мөн үетэй харьцуулахад уушгины сүрьеэ 106 тохиолдол буюу 3.7 хувиар буурч, уушгины бус эрхтний сүрьеэ 204 тохиолдол буюу 3.7 хувиар нэмэгджээ.

Зураг 2.3. Сүрьеэгийн шинэ өвчлөл, насны ангиллаар, хувиар, 2015 он



2015 онд улсын хэмжээнд 0-15 хүртэлх насны хүүхдийн сүрьеэгийн 421 тохиолдол бүртгэгдсэн нь нийт сүрьеэгийн шинэ өвчлөлийн 9.9%-ийг эзэлж байна. Улаанбаатар хотод 261 хүүхэд сүрьеэгээр өвчилсөн нь нийт хүүхдийн сүрьеэгийн өвчлөл дотор 61.9%-ийг эзэлж байна. Хүүхдийн сүрьеэгийн өвчлөл Баянгол (11.2), Хан Уул (10.6), Багахангай (17.1) дүүргүүдэд Улаанбаатар хотын дунджаас дээгүүр байна.

Зураг 2.4. Хүүхдийн сүрьеэгийн өвчлөл, тухайн насны 10000 хүн амд, 2015 он



2015 онд 0-15 хүртэлх насны 421 хүүхэд сүрьеэгээр өвчилсөн байна. Үүнээс: уушгины 65, уушгины бус эрхтний 356 тохиолдол бүртгэгдсэн.

Хүүхдийн сүрьеэгийн хүнд хэлбэрээс хурц тархмал 6, сүрьеэгийн менингит 2 тохиолдол бүртгэгдсэн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хурц тархмал сүрьеэ 2 тохиолдлоор нэмэгдэж, сүрьеэгийн менингит 2 тохиолдлоор буурсан байна.

Оношийн баталгаажилт:

2015 онд онош баталгаажилтын хувь улсын хэмжээнд 77.6 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.0 хувиар нэмэгдсэн байна.

УБ хотын хэмжээнд оношийн баталгаажилт 77.4 хувьд хүрсэн хэдий ч Багануур, Багахангай, СЭМҮТ-ийн оношийн баталгаажилт доогуур үзүүлэлттэй байна.

Эмчилгээний үр дүн:

Халдвартай шинэ сүрьеэтэй өвчтөний эмчилгээний амжилт 84.3 хувь, эдгэрэлт 79.5 хувь байгаа нь 2014 оны мөн үетэй харьцуулахад эмчилгээний амжилт 1.0 хувь, эдгэрэлт 0.9 хувиар буурсан байна.

УБ хотын хэмжээнд эдгэрэлтийн түвшин зорилтот түвшинд хүрээгүй буюу 74.3% байгаа ба хүн амын эмзэг бүлгийн хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг Энэрэл эмнэлэг, Сонгинохайрхан, Баянзүрх, Хан-Уул Сүхбаатар, Багахангай дүүргүүдийн үзүүлэлтүүд улсын дунджаас доогуур байна.

Эмэнд тэсвэртэй сүрьеэ:

Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн өвчлөл жил бүр нэмэгдсээр байгаа ба 2015 онд улсын хэмжээнд эмэнд тэсвэртэй сүрьеэ /ЭТС/ -ийн 278 тохиолдол бүртгэгдсэн ба үүнээс 101 тохиолдол буюу 36.3% нь аймаг орон нутгаас, 174 буюу 62.6% нь УБ хотоос, 3 тохиолдол буюу 1.1% хорихын эмнэлгүүдээс тус тус бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн тохиолдлуудаас Дархан-Уул, Дорноговь, Сэлэнгэ аймаг, БГД, БЗД, СХД, СБД, ХУД, ЧД-үүдэд ЭТС-ийн өвчлөл өндөр байна.

Эмчилгээнд орсон ЭТС-тэй 278 өвчтөний 158 (56.8%) эрэгтэй, 120 (43.2%) эмэгтэй, хүйсийн харьцаа 1.3:1 байна. 2013 онд ОЭТС-ийн 212 тохиолдол эмчилгээнд хамрагдсан. Эдгээрээс 3 тохиолдол одоо эмчилгээ нь үргэлжилж байгаа тул нийт 209 өвчтөний эмчилгээний үр дүнг тооцоход эмчилгээний амжилт 62.2% байна.

Хүснэгт 2.4. Сүрьеэ өвчний тархалт, нас баралтын түвшин 100 000 хүн амд

Үзүүлэлт	1996	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Сүрьеэгийн өвчлөлийн түвшин											
Улсын дундаж	146	189	168	160	157	154	143	139	142	141	141
УБ хот	189	248	217	205	199	189	174	170	179	187	185
Аймгийн дундаж	122	149	145	140	131	136	126	119	110	101	109
Сүрьеэгийн нас баралтын түвшин											
Улсын дундаж	4.9	2.9	2.5	2.7	2.8	3.3	2.2	2.1	2.0	1.9	1.7
УБ хот	4.1	3.3	2.3	3.2	2.7	4.4	2.4	2.2	2.4	2.3	2.3
Аймгийн дундаж	2.4	2.5	2.6	2.4	2.9	2.5	1.9	2.0	1.7	1.6	1.7
ДОТС-ын хүрээнд эмчилсэн сүрьеэгийн тохиолдлын хувь											
Улсын дундаж	100 /66.2	100 /82.1	100 /83.8	100 /85.0	100 /82.4	100 /84.5	100 /83.0	100 /82.7	100 /80.1	100 /80.7	100 /79.5
УБ хот	100 /62.7	100 /78.0	100 /84.2	100 /86.4	100 /80.7	100 /81.7	100 /79.8	100 /78.0	100 /76.0	100 /77.1	100 /74.3
Аймгийн дундаж	100 /68.5	100 /87.1	100 /88.0	100 /87.2	100 /87.8	100 /87.5	100 /87.3	100 /89.2	100 /84.7	100 /85.2	100 /88.3

Бүлэг III. ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ


3.1. ЖИРЭМСНИЙ ХЯНАЛТ, ТӨРӨХИЙН ӨМНӨХ ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Төрөхийн өмнөх үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь жирэмснийг эрт илрүүлж, жирэмсэн эмэгтэйчүүдийг жирэмсний эрт үед хяналтанд авч, жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа эмчийн хяналтанд хамруулах, жирэмсэн эхчүүдийг цусны ерөнхий шинжилгээ, БЗДХ-ын шинжилгээнд бүрэн хамруулах нь цус багадалт, жирэмсний хожуу хордлого, бөөрний эмгэг, ургийн болон бусад эмгэгийг эрт илрүүлж, жирэмслэлт төрөлтийн хүндрэлээс сэргийлэх, хүндрэлийг эрт илрүүлж цаг алдалгүй эмчлэх, хавсарсан өвчнийг оношлох, эмчлэх мөн жирэмсний болон төрөх үеийн хүндрэлийг бууруулахад чиглэгдэж байна.

3.1.1. Жирэмсний хяналт


2015 оны жилийн эцсийн байдлаар НЭМГ-ын харьяа эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад жирэмсэн эмэгтэйчүүдийн 84.1 хувь нь жирэмсний эхний 3 сартайд, 14.2 хувь нь 4-6 сартайд, 1.7 хувь нь 7 ба түүнээс дээш сартайд хяналтанд хамрагдсан байна.

Зураг 3.1.1. Жирэмсний эрт хяналтын хувь, 2011-2015 он



Жирэмсний эрт хяналтын хувь 84.1 болж, өмнөх оноос 1.3 хувиар буурсан ба аймаг, улсын дунджаас 0.1-0.2 хувиар бага үзүүлэлттэй байна.

Зураг 3.1.2. Жирэмсний эрт хяналтын хувь, дүүргээр, 2014-2015 он



НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн хяналтанд хамрагдсан нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 99.6 хувь нь цусны шинжилгээнд хамрагдсан ба 3.1 хувь нь цус багадалттай байгаа нь улсын дунджаас 0.8-аар, аймгийн дунджаас 1.6-аар тус тус бага байна.


Шинээр хяналтанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс 99.1 хувь нь БЗДХ илрүүлэх, 97.5 хувь нь вирүст хепатит В,С илрүүлэх, 84.5 хувь нь рентген шинжилгээнд тус тус хамрагдсанаас 3.5 хувьд нь тэмбүү, 0.4 хувьд нь заг хүйтэн, 1.7 хувьд нь трихомониаз, 0.1 хувьд нь идэвхтэй сүрьеэ, 1.3 хувьд нь вирүст хепатит В, 0.6 хувьд нь вирүст хепатит С тус тус илэрсэн байна.

Хүснэгт 3.1.1. Жирэмсэн эмэгтэйчүүдийн шинжилгээнд хамрагалт, 2015 он

Үзүүлэлт		Анх
Тухайн онд бүртгэгдсэн жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо		41287
Цусны шинжилгээ	Шинжилгээнд хамрагдсан	41117
	Үүнээс: Цус багадалттай (Hb хэмжээ 110г/л-ээс бага)	1275
Вирүст хепатит В	Шинжилгээнд хамрагдсан	40263
	Үүнээс: эерэг	522
Вирүст хепатит С	Шинжилгээнд хамрагдсан	40235
	Үүнээс: эерэг	261
Тэмбүүгийн шинжилгээ	Шинжилгээнд хамрагдсан	40898
	Үүнээс: эерэг	1430
ХДХВ/ДОХ-ын шинжилгээ	Шинжилгээнд хамрагдсан	40053
	Үүнээс: эерэг	0
Заг хүйтэн илрүүлэх шинжилгээ	Шинжилгээнд хамрагдсан	40898
	Үүнээс: эерэг	156
Трихомониаз илрүүлэх шинжилгээ	Шинжилгээнд хамрагдсан	40898
	Үүнээс: эерэг	688
Рентген шинжилгээ		34891
Идэвхтэй сүрьеэтэй		32
Резус	Хамаарал үзсэн	29812
	Резус (-)	64

2015 оны байдлаар улсын хэмжээнд нийт төрсөн эхчүүдийн 91.2 хувь нь жирэмсний хугацаандаа 6 ба түүнээс дээш удаа үзүүлж хяналтанд байж төрсөн бол Улаанбаатар хотод төрсөн эхчүүдийн 99.5 хувь нь, НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд төрсөн эхчүүдийн 99.7 хувь нь жирэмсний хугацаандаа 6 ба түүнээс дээш удаа үзүүлж хяналтанд хамрагдсан нь өмнөх онтой харьцуулахад 7.0 хувиар, улсын дүнгээс 8.5 хувиар, аймгийн дүнгээс 17.1 хувиар дээгүүр үзүүлэлттэй байна.

Зураг 3.1.3. Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь, 2007-2015 оноор



3.2. ТӨРӨЛТ, ТӨРӨХ ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих төрөөс баримталж буй бодлого салбарын тэргүүлэх чиглэл болоход олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд төрөлт нэмэгдэж, тусламж үйлчилгээ сайжирсаар байна. 2015 онд “Амгалан” амаржих газрын 150 ор бүхий шинэ байр ашиглалтанд орсноор хүчин чадлын хувьд 3 дахин нэмэгдэх боломж бүрдсэн байна.

2015 онд Улсын хэмжээнд 80434 эх төрсөн нь өмнөх оноос 786 төрөлтөөр буюу 1.0 хувиар буурсан бол Улаанбаатар хотод 41447 эх төрж өмнөх онтой харьцуулахад төрөлт 20 тохиолдлоор буюу 0.04 хувиар нэмэгджээ.

Хүснэгт 3.2.1. Төрөлтийн тоо, эмнэлгийн байгууллагын төрлөөр, 2015 он

Эмнэлгүүд	Нийт төрөлт	Гэрийн төрөлт	Хөдөөнөөс ирж төрсөн эхчүүд	Мэс заслын аргаар төрүүлсэн	Эмнэлгийн мэргэжилтэн эх барьсан хувь
Өргөө амаржих газар	15917	61	97	5131	99.8
Хүрээ амаржих газар	5273	30	78	1388	99.7
Амгалан амаржих газар	6059	27	57	1374	99.6
Багануур ЭМТ	734	3	117	207	99.7
Налайх ЭМТ	838	0	36	187	100
ЭХЭМҮТ	11020	66	4947	3147	99.8
Хувийн эмнэлэг	1577	0	92	732	100
ХӨСҮТ	24	0	3	7	100
Тосгоны эмнэлэг	5	0	0	0	100
Бүгд	41447	187	5427	12173	99.8

Мэдээллийн эх сурвалж: 2015 оны төрөлтийн бааз мэдээлэл


2015 онд Улаанбаатар хотод хөдөө орон нутгаас 5427 эх ирж төрсөн нь нийт төрөлтийн 13.1 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх оноос 466 төрөлтөөр буюу 8.6 хувиар буурсан байна.

Гэрийн төрөлтийн 187 тохиолдол бүртгэгдсэн нь нийт 0.45 хувийг эзэлж байгаа ба өмнөх оны үзүүлэлтээс 31 тохиолдлоор буюу 0.1 хувиар нэмэгдсэн байна.

Гэрийн төрөлтийн нийт тохиолдлын 23.5 хувь нь хөдөө орон нутгийн, 76.5 хувь нь УБ хотын харьяалалтай иргэд эзэлж байна.


МХЗ-ын нэг үзүүлэлт болох эмнэлгийн мэргэжилтэн эх барьсан төрөлтийн хувь 2015 онд 99.8 хувьд хүрсэн нь зорилтоо хангасан байна.

Зураг 3.2.1. Улаанбаатар хотод хөдөө орон нутгаас ирж төрсөн эхчүүд, бодит тоо, 2014-2015 он



Нийт төрөлтийн 29.4 хувь нь мэс заслын аргаар төрсөн байна. ДЭМБ-ын зөвлөснөөр нийт төрөлтийн 5-15 хувь нь мэс заслын аргаар төрүүлж болно гэж үздэг байна. Улаанбаатар хотын хувьд 29.4 хувь нь мэс заслын аргаар хүүхдээ төрүүлсэн байгаа нь өмнөх оноос 0.4 хувиар буурсан, улсын дунджаас 4.6 хувиар, аймгийн дунджаас 9.5 хувиар тус тус их байна.

Зураг 3.2.2. Нийт төрөлтөд мэс заслын аргаар төрүүлсэн төрөлтийн эзлэх хувь, бүртгэгдсэн эрүүл мэндийн байгууллагаар, 2014-2015 он



НЭМГ-ын харьяа амаржих газрууд, Багануур ЭМТ, Налайх ЭМТ, “Хатагтай”, “Таны төлөө бид” хувийн эмнэлгүүдэд 29096 төрөлт буюу нийт төрөлтийн 70.2 хувь нь, ЭМСЯ-ны харьяа ЭХЭМҮТ, ХӨСҮТ, Гурван гал хувийн эмнэлгүүдэд 12351 төрөлт буюу 29.8 хувь нь төрсөн байна.

Төрсөн эхчүүдээс анхны төрөлт 33.4 хувь, 1 жилийн зайтай төрсөн эх 4.2 хувь, 2 жилийн зайтай төрсөн эх 12.6 хувь, 3 ба түүнээс дээш жилийн зайтай төрсөн эх 49.8 хувь байна. Нийт төрөлтөд 35-аас дээш насны төрөлт 16.1 хувь, 20 хүртэлх насны төрөлт 4.9 хувийг эзэлж байна.

Төрөлтийг насны ангиллаар авч үзхэд 20 хүртэлх насны төрөлт 4.9 хувь, 20-24 насны төрөлт 25.4 хувь, 25-29 насны төрөлт 31.7 хувь, 30-34 насны төрөлт 21.9 хувь, 35-39 насны төрөлт 12.8 хувь, 40-44 насны төрөлт 3.2 хувь, 45-49 насны төрөлт 0.1 хувийг тус тус эзэлж байгаа ба анхны төрөлт 33.4 хувь, 6 ба түүнээс дээш төрөлт 0.5 хувийг эзэлж байна.

Зураг 3.2.3. Нийт төрөлт, насны ангиллаар, 2015



Нийт төрөлтийн 98.7 хувийг эх барих, эмэгтэйчүүдийн эмч, 0.3 хувийг их эмч, 0.8 хувийг эх баригч бага эмч, 0.2 хувийг мэргэжлийн бус хүн удирдаж төрүүлсэн байна.

Зураг 3.2.4. Төрөлтийн тусгай коэффициент, нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйд, дүүргээр, 2015 он

Энэ үзүүлэлт нь нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн төрөлтийн түвшинг илэрхийлдэг. Төрөлтийн тусгай коэффициентийг тооцоход нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэй тутмын 90 нь хүүхэд төрүүлсэн байна. Энэ нь 2014 онтой харьцуулахад 1-ээр буурсан байна.

Хүснэгт 3.2.2. Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент, 2015 он

Насны бүлэг	Тухайн насны эмэгтэйчүүдийн тоо	Тухайн насны эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоо	Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент
15-19 нас	47041	1563	33.2
20-24 нас	61450	8462	137.7
25-29 нас	79627	11789	148.0
30-34 нас	65614	8247	125.7
35-39 нас	57136	4753	83.2
40-44 нас	49392	1165	23.6
45-49 нас	41867	35	0.8

Энэ үзүүлэлт нь эмэгтэйчүүдийн насны бүлгүүд дэх төрөлтийн ялгавартай түвшинг илэрхийлнэ. Насны бүлэг дотор 20-24 насны 1000 эмэгтэй тутмын 138 нь, 25-29 насны 1000 эмэгтэй тутмын 148 нь, 30-34 насны 1000 эмэгтэй тутмын 126 нь хүүхэд төрүүлж байгаа нь өндөр үзүүлэлттэй байна.

Төрөлтийн нийлбэр коэффициентийг насны бүлэг дэх төрөлтийн коэффициентийг ашиглан тооцоход 2.7 байгаа нь нэг эмэгтэй нийт амьдралынхаа туршид дунджаар 3 хүүхэд төрүүлж буйг илэрхийлж байна.

Амьгүй төрөлтийн 329 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 68 тохиолдлоор буюу 20.6 хувиар буурсан байна. Амьгүй төрөлтийн 22.5 хувь нь хөдөө орон нутгаас, 77.5 хувь нь УБ хотоос бүртгэгдсэн байна.

Зураг 3.2.5. Амьгүй төрөлтийн түвшин, 1000 нийт төрөлтөд, дүүргээр, 2014-2015 он



Амьгүй төрөлтийн түвшин Налайх, Багануур дүүргүүдэд хотын дунджаас өндөр байна.


3.3. ТӨРСНИЙ ДАРААХ ҮЕИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

2015 оны байдлаар НЭМГ-ын харьяа өрх, тосгоны эмчийн эмнэлгийн хяналтанд байж төрсөн эхчүүдээс 93.7 хувь нь төрсний дараа 42 хоногтойдоо идэвхитэй хяналтанд хамрагдсан байна. Энэ нь өмнөх оноос 0.6 хувиар буурсан бол улсын дундаж /89.5/ үзүүлэлтээс 4.2 хувиар, аймгийн дунджаас 3.8 хувиар их байна. Энэ нь төрсний дараах хүндрэл болон эхийн эндэгдэл буурахад чухал ач холбогдолтой үзүүлэлт юм.

2015 оны байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл 39362 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 5734 тохиолдол буюу 14.6 хувиар нэмэгдсэн байна. Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа амаржих газрууд, дүүргийн эрүүл мэндийн төвүүд, хувийн эмнэлгүүдэд жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн нийт 28420 тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос 4942-оор нэмэгдэж, нийт УБ хотод бүртгэгдсэн хүндрэлийн 72.2 хувийг эзэлж байна.

Жирэмсэн, төрөх, төрсний дараах хүндрэлийн 27711 тохиолдол буюу 97.5 хувь нь амаржих газруудад, 709 тохиолдол буюу 2.5 хувь нь Багануур, Налайх дүүргүүдийн эрүүл мэндийн төвд бүртгэгдсэн байна.

Зураг 3.3.1. НЭМГ-ын харьяа байгууллагуудад бүртгэгдсэн жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл, хувиар, 2012-2015 он



Жирэмсэн үеийн хүндрэл өмнөх оноос 0.2 хувиар буурсан ба жирэмсэн үеийн хүндрэл дотор манас таталтын урьтал болон манас таталт 17.8 хувь, ихэс түрүүлэлт 1.4 хувь, ихэс цагаасаа өмнө ховхрох 1.3 хувь, даралт ихсэх 11.0 хувь, чихрийн шижин 0.3 хувь, бусад 68.2 хувийг эзэлж байна.

Төрөх үеийн хүндрэл өмнөх оноос 1.2 хувиар буурсан ба ус эрт гарах 27.3 хувь, төрөх хүчний сулралт 23.4 хувь, хүүхдийн буруу байрлалаас төрөлт саатах 6.5 хувь, эхийн аарцаг ясны хөгжлийн гажгаас төрөлт саатах 2.5 хувь, хязангийн урагдалт 8.6 хувь, умайн хүзүүний урагдал 0.8 хувь, умайн урагдал 0.1 хувь, төрөх үеийн цус алдалт 0.1 хувь, ихэс түдэлт 0.4 хувь, бусад 30.3 хувийг тус тус эзэлж байна.

Төрсний дараах хүндрэл өмнөх оноос 0.2 хувиар буурсан ба төрсний дараах эрт үеийн /4цаг/ цус алдалт 41.7 хувийг, хожуу цус алдалт 2.5 хувийг, төрсний дараах халдвар 21.2 хувь, бусад 35.0 хувийг тус тус эзэлж байна.

Нийт хүндрэлийн дотор 3.8 хувийг жирэмсэн, төрөхөөс үл хамаарах өвчний хүндрэл эзэлж байгаа ба өмнөх оноос 2.0 хувиар нэмэгдсэн байна.

3.4. ЭХИЙН ЭНДЭГДЭЛ

Дэлхийн мянганы хөгжлийн зорилтод эхийн эндэгдлийг 2015 онд 1990 онтой харьцуулахад 4 дахин бууруулахаар заасан.


Монгол Улсын Засгийн газрын 61 дүгээр тогтоолоор “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний 4 дэх хөтөлбөрийг баталснаар нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлж, хүн амын тогтвортой өсөлтийг дэмжихэд чиглэсэн МХЗ-ыг хангахад ахиц болсон.

2015 онд Нийслэлийн Өргөө амаржих газарт 23 ортой эмгэг нярайн тасаг, Багануур ЭМТ-д 8 ортой эмгэг нярайн тасаг тус тус байгуулснаар нийслэлийн хэмжээний эх болон нярайн эндэгдэл буурах, тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэх таатай нөхцөл бүрдсэн.

Улсын хэмжээнд 2015 оны байдлаар эхийн эндэгдлийн 21 тохиолдол бүртгэгдсэнээс 12 тохиолдол нь Улаанбаатар хотод бүртгэгдэж, 100 000 амьд төрөлтөд 28.8 болсон нь улсын дунджаас 2.8-аар өндөр үзүүлэлттэй байна. Эндсэн эхчүүдийн 3 буюу 25.0 хувь эх барихын шууд шалтгаантай, 9 буюу 75.0 хувь нь эх барихын шууд бус шалтгаантай эндэгдэл байна.


Эхийн эндэгдлийн 9 тохиолдол буюу 75.0 хувь нь УБ хотын харьяалалтай байгаагаас дүүргээр авч үзвэл Чингэлтэй 4, Баянзүрх 3, Сонгинохайрхан, Хан-уул дүүргүүдэд тус тус 1 эх эндсэн байна. 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл Баянзүрх дүүрэгт 38.4, Чингэлтэй дүүрэгт 86.0 байгаа нь хотын дунджаас 9.6-57.2-оор өндөр байна. Эхийн эндэгдэл Баянгол, Сүхбаатар, Налайх, Багануур, Багахангай дүүргүүдэд бүртгэгдээгүй байна. Хөдөө орон нутгаас 25.0 хувь буюу 3 эх энджээ.

Зураг 3.4.1. Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд, сонгосон оноор



Улаанбаатар хотод бүртгэгдсэн эхийн эндэгдлийн 12 тохиолдлоос 5 буюу 41.6 хувийг НЭМГ-ын харьяа эмнэлэг, 7 тохиолдол буюу 58.4 хувийг ЭМСЯ-ны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд мэдээлсэн ба эндсэн газраар нь авч үзвэл 1 эх бусад газарт, 11 эх нь эмнэлэгт эндсэн байна.


Зураг 3.4.2. Эхийн эндэгдэл, бүртгэгдсэн эрүүл мэндийн байгууллагаар, 2015 он



Эндсэн эхчүүдийг насны ангиллаар авч үзвэл: 16.7 хувь нь 15-19 насны, 8.3 хувь нь 20-24 насны, 24.9 хувь нь 25-29 насны, 8.3 хувь нь 30-34 насны, 33.4 хувь нь 35-39 насны, 8.3 хувь нь 40-44 насны эмэгтэйчүүд эзэлж байна. Боловсролын түвшингээр нь авч үзвэл 50 хувь нь дээд боловсролтой, 42 хувь нь дунд боловсролтой, 8 хувь нь боловсролгүй эхчүүд эзэлж байна.

Зураг 3.4.3.

Эндсэн эхчүүд, насны ангиллаар, 2015 он



Эндсэн эхчүүд, ажил эрхлэлтээр, 2015 он





3.5. ЖИРЭМСЛЭЛТЭЭС СЭРГИЙЛЭХ ОРЧИН ҮЕИЙН АРГЫН ХЭРЭГЛЭЭ

Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга /ЖСА/ нь хүсээгүй жирэмслэлт, хууль бус үр хөндөлт мөн төрөлт хоорондын зайг зохицуулахад чухал ач холбогдолтой юм.

2015 оны байдлаар төрөх насны эмэгтэйчүүдийн 49.5 хувь нь ЖСА хэрэглэдэг гэсэн статистик үзүүлэлт байгаа нь өмнөх оноос 4.6-аар буурсан ба нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйчүүдийн 494.7 нь жирэмслэлтээс сэргийлэх ямар нэг аргыг хэрэглэж байгаа нь өмнөх оны мөн үеэс 46.2-оор буурсан байна.

Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бэлгэвчийн хэрэглээ 35.0 хувь байгаа нь өмнөх оноос 2.0 хувиар буурч, ерөндөг 1.0 хувиар, дааврын эм 1.0 хувиар, норплант 1.0 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 3.5.1. Жирэмслэлтээс сэргийлэх арга, 2015 он**Зураг 3.5.2.** ЖСА хэрэглэж байгаа нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь, 2009-2015 он

3.6. ҮР ХӨНДӨЛТ

Улсын хэмжээнд 2015 оны байдлаар үр хөндөлтийн 18168 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 224.6, нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйд 22 үр хөндөлт ногдож байна.

Улаанбаатар хотын эмнэлгүүдэд үр хөндөлтийн 13164 тохиолдол бүртгэгдсэн нь нийт үр хөндөлтийн 72.5 хувийг эзэлж байгаа ба 1000 амьд төрөлтөд 315.4, нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэй тутмын 32.7 нь үр хөндүүлсэн нь өмнөх оноос 1264 тохиолдол буюу нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэй тутамд 2.8-аар нэмэгдсэн байна.


ЭХЭМҮТөвд 2592 тохиолдол буюу 19.7 хувь нь, НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд 10499 тохиолдол буюу 79.7 хувь нь үр хөндүүлсэн байна.

Хүснэгт 3.6.1. Үр хөндөлт, бүртгэгдсэн эмнэлгийн байгууллагаар, 2012-2015 он

Эрүүл мэндийн байгууллага	2012 он		2013 он		2014 он		2015 он	
	Бүртгэгдсэн үр хөндөлтийн тоо	Нийт үр хөндөлтөд эзлэх хувь	Бүртгэгдсэн үр хөндөлтийн тоо	Нийт үр хөндөлтөд эзлэх хувь	Бүртгэгдсэн үр хөндөлтийн тоо	Нийт үр хөндөлтөд эзлэх хувь	Бүртгэгдсэн үр хөндөлтийн тоо	Нийт үр хөндөлтөд эзлэх хувь
ЭХЭМҮТ	2375	24.27	3127	30.11	3160	26.55	2592	19.69
Амаржих газрууд	3538	36.15	4766	45.89	5914	49.69	8011	60.85
Дүүргийн ЭМТөв	112	1.14	116	1.11	116	0.97	68	0.51
Хувийн эмнэлэг	3716	37.97	2348	22.60	2703	22.71	2473	18.78
Бусад /ТЗТЭ/	44	0.44	28	0.26	7	0.05	20	0.15
Бүгд	9785		10385		11900		13164	

Амаржих газруудад өмнөх оноос 2097 тохиолдлоор нэмэгдэж, хувийн эмнэлэгт хийсэн үр хөндөлт буурсан нь нэг талаас бүртгэж мэдээлэхгүй байгаатай холбоотой.

Зураг 3.6.1. Үр хөндөлт, 1000 амьд төрөлтөд, 2009-2015 он




1000 амьд төрөлтөд ногдох үр хөндөлт аймгийн дунджаас 187.6-р, улсын дунджаас 90.8-р тус тус өндөр байна.

НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 2.7 хувь нь хожуу үр хөндүүлсэн ба өмнөх оноос 0.5 хувиар нэмэгдсэн байна. Үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 6.2 хувь нь төрөөгүй эмэгтэйчүүд эзэлж байгаа нь өмнөх оноос 5.9 хувиар буурсан. 20-оос доош насны үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн хувь 4.9 болж өмнөх оны түвшинд, улсын дунджаас 0.2 хувиар бага үзүүлэлттэй байна.


НҮЭМ-ийн /2012-2016/ үндэсний хөтөлбөрт үр хөндөлтийг 1000 амьд төрөлтөд 2016 онд хүрэх түвшинг 160.0 болгохоор заасан боловч улсын дундаж 224.6, Улаанбаатар хотод 315.4 байгаа нь анхаарал татсан асуудал болж байна.

Зураг 3.6.2. НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд 20-оос доош насны үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, 2009-2015 он



Нийгмийн байдлаар нь авч үзвэл ажилчин 49.9, оюутан 10.2, ажилгүй 35.0, малчин 2.0, бусад 3.0 хувийг тус тус эзэлж байна. Үр хөндөлтөөс гарсан хүндрэлийн эзлэх хувь өмнөх оноос 0.4 хувиар буурсан ба улсын дунджаас 0.1-ээр бага байна. Хүндрэлийн 12.5 хувийг умайн агшилт суларч цус алдсан, 12.5 хувийг умай цоорсон, 6.3 хувийг үжил халдвар, 68.8 хувийг умайн дайврын үрэвсэл тус тус эзэлж байна.

Зураг 3.6.3. НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд бүртгэгдсэн үр хөндөлтийн хүндрэлийн эзлэх хувь, 2011-2015 он



3.7. ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Шинээр төрсөн хүүхдийг нярай үед нь буюу төрсний дараах нэг сар хүртэлх хугацаанд нь хамрагдвал зохих эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд хамруулснаар амьдрах боломжийг нэмэгдүүлж, хэвийн өсөлт хөгжилтэй, эрүүл саруул өсөх үндэс болдог.

2015 оны байдлаар улсын хэмжээнд 80875 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оны мөн үеэс 840 хүүхдээр буюу 1.0 хувиар буурсан байна. Амьд төрсөн хүүхдийн 1869 нь 2 ихэр, 35 нь 3 ихэр хүүхэд байна.

Улаанбаатар хотод нийт 41731 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оноос 55 хүүхдээр буурсан байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 70.0 хувь буюу 29221 хүүхэд НЭМГ-ын харьяа амаржих газар, дүүргийн эрүүл мэндийн төв болон хувийн эмнэлэгт төрсөн ба 51.3 хувь нь хүү, 48.7 хувь нь охин мэндэлж, 97.6 хувь нь 1 цагийн дотор хөхөө амлаж, 99.3 хувь нь БЦЖ, 98.5 хувь нь саа, 99.4 хувь нь хепатитын вакцин хийлгэсэн байна. Амьд төрсөн нярайн 594 нь 2 ихэр, 4.9 хувь нь дутуу, 0.3 хувь нь бүтэлтэй төрсний 44.3 хувь нь амьдарч, 55.7 хувь нь нас барсан байна. Амьд төрсөн нярайн 0.6 хувьд нь төрөлхийн гажигтай нярай бүртгэгдсэн байна.

Амьгүй төрсөн 175 хүүхдийн 3.4 хувь 2 ихэр, 20.0 хувь нь 22-28 долоо хоногтой дутуу төрсөн нярай, 58.3 хувь нь 2500 граммаас бага жинтэй хүүхэд төрсөн байна.

Хүснэгт 3.7.1. Амьд төрсөн хүүхэд, бүртгэгдсэн эрүүл мэндийн байгууллагуудаар, 2015 он

Эрүүл мэндийн байгууллагууд	Төрсөн хүүхэд					Амьгүй төрөлтийн түвшин /1000 нийт төрөлтөд/
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа /100-д/	Бага жинтэй хүүхдийн эзлэх хувь	
Амаржих газрууд	27367	14037	13330	105.3	2.7	5.9
Эрүүл мэндийн төв	1576	799	777	102.8	3.6	8.2
Хувийн эмнэлэг	272	146	126	115.8	0.4	0.0
Тосгоны эмнэлэг	6	3	3	100	33.3	0.0
НЭМГ-ын дүн	29221	14985	14236	105.3	2.7	6.0
Улаанбаатар	41731	21462	20269	105.8	4.9	7.8
Аймгийн дүн	39144	20088	19056	105.4	3.8	5.8
Улсын дүн	80875	41560	39325	105.6	4.4	6.9

Улаанбаатар хотод нярай үедээ бүртгэгдсэн хүүхдийн өвчлөлийн 8494 тохиолдол байгаа ба өмнөх оноос 1379-аар нэмэгдэж, амьд төрсөн хүүхдийн 20.4 хувь нь өвчилсөн бол НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд 1794 буюу 21.1 хувь нь бүртгэгдэж, амьд төрсөн хүүхдийн 6.1 хувь нь өвчилсөн байна. Нярай хүүхдийн өвчлөлийн аймгийн дундаж /21.2/, улсын дундаж /20.8/ байна.

Улаанбаатар хотын нярайн өвчлөл дотор перинаталь үед үүссэн эмгэг 88.1 хувийг эзэлж байгаа бол НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд 72.3 байна. Үүнээс: нярайн амьсгалын гачаал 9.6 хувь, төрөхөд бүтэх 8.1 хувь, нярайн шарлалт 8.6 хувь, уушгины төрөлхийн хатгаа 5.1 хувь, ургийн тураал 3.7 хувийг эзэлж тэргүүлэх шалтгаан болж байна. Төрөлхийн гажгийн 430 тохиолдол бүртгэгдсэн ба өмнөх оноос 3 тохиолдол буюу 0.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 3.7.2. Нярай хүүхдийн өвчлөл, 2015 он


	Нийт өвчлөл	Перинаталь үед үүссэн зарим эмгэг	Халдварт ба шимэгчит өвчин		Амьсгалын тогтолцооны өвчин		Хоол шингээх эрхтний эмгэг		Төрөлх гажиг, гаж хөгжил	Хромсомын эмгэг	Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант эмгэг	Бусад өвчин
			Бүгд	Төрөлхийн тэмбүү	Бүгд	Уушгины хатгаа	Бүгд	Халдварт бус суулгалт өвчин				
Аймгийн дүн	8305	6332	65	15	929	272	114	68	228	22	14	601
Улаанбаатар	8494	7484	29	22	216	5	77	18	430	31	10	217
Улсын дүн	16799	13816	94	37	1145	277	191	86	658	53	24	818

3.8. НЯЛХАС БОЛОН ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ


УИХ-ын “Мянганы хөгжлийн зорилтуудыг батлах тухай” 13 дугаар тогтоолоор Мянганы хөгжлийн зорилтын хүрээнд 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийг 2015 онд 15.0, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 21.0 хүртэл бууруулахаар заасан.

Хүүхдийн эндэгдэл сүүлийн жилүүдэд тогтвортой буурч байгаа нь хөхөөр хооллолт, өргөн дархлаажуулалт, хүүхдийн өвчний цогц менежмент зэрэг нийгмийн эрүүл мэндийн оновчтой арга хэмжээг амжилттай авч хэрэгжүүлж байгаатай шууд холбоотой юм.

Зураг 3.8.1. Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьд төрсөн 1000 хүүхдэд



Зураг 3.8.2. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьд төрсөн 1000 хүүхдэд



2015 оны байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд нялхсын эндэгдлийн 613 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 12 тохиолдлоор буюу 1.9 хувиар, амьд төрсөн 1000 хүүхдэд 14.7 болж 0.3 промилиор буурсан байна.

Нялхсын эндэгдлийн 18.9 хувь нь НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд, 81.1 хувь нь ЭМСЯ-ны харьяа эмнэлгүүдэд эндсэн байна. Нялхсын эндэгдэл Налайх дүүрэгт Улаанбаатар хотын дунджаас 0.9-өөр өндөр байна.

Нийт нялхсын эндэгдлийн 53.2 хувь нь нярайн эрт үед, 17.9 хувь нь нярайн хожуу үед, 28.9 хувь нь 29-365 хүртэлх хоногтойдоо эндсэн байна.

НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд бүртгэгдсэн нялхсын эндэгдлийн 61.2 хувь нь эрт үед, 6.9 хувь нь нярайн хожуу үед, 31.9 хувь нь 29-365 хүртэлх хоногтойдоо эндсэн байна.

Хүснэгт 3.8.1. Эх, хүүхдийн эндэгдэл, бүртгэгдсэн эрүүл мэндийн байгууллагаар, 2015 он


	Эмнэлгийн нэр	Нас баралт					
		Эхийн эндэгдэл	1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	Үүнээс			1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл
				0-6 хоногтой	7-28 хоногтой	29-1 хүртэлх настай	
1	БЗДЭМТ		5		1	4	2
2	БГДЭМТ		1			1	
3	СХДЭМТ	1	4			4	2
4	ЧДЭМТ	1	2			2	2
5	БндЭМТ		8	2	2	4	1
6	НадЭМТ		11	5		6	
7	СБДЭМТ		0				
8	ХУДЭМТ		3			3	
9	Өргөө амаржих газар	2	43	39	4		
10	Хүрээ амаржих газар		14	13	1		
11	Амгалан амаржих газар	1	11	11			
12	СХНЭ	0	5			5	2
13	СБНЭ		1			1	1
14	ХУНЭ		0				
15	БЗНЭ		6			6	7
16	Багахангай		1			1	1
17	Гачуурт		0				1
18	Хувийн эмнэлэг		1	1			
НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн дүн		5	116	71	8	37	19
1	ЭХЭМҮТөв	3	431	244	95	92	23
2	Шүүх эмнэлэг	1	49	11	7	31	25
3	УНТЭ		0				
4	ХСҮТ	1	0				4
5	ХӨСҮТ	2	13			13	1
6	ГССҮТөв		3			3	38
7	УГТЭ		1			1	
ЭМСЯ-ны харьяа эмнэлгүүдийн дүн		7	497	255	102	140	91
Бүгд		12	613	326	110	177	110

Улсын хэмжээнд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 1476 тохиолдол бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 723 тохиолдол буюу 48.9 хувь нь бүртгэгдсэн байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлээс тогтмол хаягаар авч үзэхэд УБ хотын харьяаллын тав хүртэлх насны хүүхдийн нас баралт 505 болж өмнөх оноос 23 тохиолдлоор буурсан байна.

Улаанбаатар хотод бүртгэгдсэн 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 613 тохиолдлын 432 нь буюу 70.5 хувь нь УБ хотын харьяаллын хүүхдүүд эндсэн байна. УБ хотод эндсэн 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл дотор хөдөө орон нутгаас 181 хүүхэд эндсэн байна.

Хүснэгт 3.8.2. Нялхас болон тав хүртэлх хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан, 2015 он

Шалтгаан	1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл		5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	
	Бодит тоо	Хувь	Бодит тоо	Хувь
Перинаталь үед үүссэн зарим эмгэг	380	61.9	380	52.5
Төрөлхийн гажиг, гаж хөгжил	80	13.1	88	12.2
Амьсгалын замын тогтолцооны өвчин	50	8.2	67	9.3
Гадны шалтгаант өвчлөл ба нас баралт	20	3.3	79	10.9
Мэдрэлийн тогтолцооны өвчин	26	4.2	31	4.3



Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл сүүлийн жилүүдэд буурсан хэдий ч перинаталь үед үүссэн эмгэг өвчлөлийн хамааралтай нас баралт тэргүүлэх шалтгаан болсоор байна.

Нярайн эрт үеийн перинаталь үед үүссэн эмгэгийн нас баралтанд нярайн амьсгалын гачаал 19.5 хувийг, төрөхөд ураг бүтэх 10.8 хувийг, нярайн тархитай холбоотой эмгэг 52.4 хувийг эзэлж байна.

Амьсгалын тогтолцооны өвчлөлөөс шалтгаалсан эндэгдэл дотор уушгины хатгаагаар 82.0 хувь, төрөлхийн гажигаас 44.9 хувийг зүрхний гажиг, 19.6 хувийг хоол боловсруулах эрхтэн тогтолцооны гажиг, 35.5 хувийг бусад эрхтэн тогтолцооны төрөлхийн гажиг тус тус эзэлж байна.

Улаанбаатар хотод бүртгэгдсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 10.9 хувийг хүүхдийн бэртэл, хордлого, осол гэмтлийн гадны шалтгаант нас баралт эзэлж байгаа бөгөөд энэ нь хүүхдийн эндэгдлийн дотор тэргүүлэх 3 дах шалтгаан болж байна.

Тав хүртэлх насны хүүхдийн бэртэл, хордлого, осол гэмтлийн гадны шалтгаант нас баралтын 79 тохиолдол бүртгэгдсэн ба 55 буюу 69.6 хувь нь УБ хотын харьяаллын хүүхэд эндсэн нь өмнөх оноос 5 тохиолдлоор буурсан байна.

Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 20 буюу 25.3 хувь нь, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 59 буюу 74.7 хувийг эзэлж байгаа бөгөөд 1-5 хүртэлх насны хүүхдийн ослоор эндсэн хувь өмнөх оноос 0.9-өөр нэмэгдсэн нь анхаарал татаж байна. Бусдад хорлогдсон, тодорхой бус шалтгаант болон зам тээврийн ослын шалтгаант эндэгдэл нэмэгдсэн байна.

Зураг 3.8.3. Нас барсан хэлбэр, хувиар, 2012-2015 он



Бусад ослоор эндсэн эндэгдлийн дотор унаж бэртсэнээс 8.0 хувь, амьсгал боогдсоноос 20.9 хувь, түлэгдэлтээр 61.2 хувь, живэх 3.2 хувь, цохигдох 1.6 хувь, осгох 1.6 хувь, хорт бодист өртөх 3.2 хувийг тус тус эзэлж байна.

Бусад ослоор эндсэн хүүхдүүдийн 61.2 хувь нь түлэгдэлтээр эндсэн нь өмнөх оноос 13.1 хувиар буурсан байна. Бусад ослын шалтгааны дийлэнх хувийг хэрэглээний халуун ус, халуун хоол, өөх тосонд, гал түймэрт түлэгдсэн, бусад хий уурын хордлогоор, юмнаас унаж ойчих, юманд цохигдох зэрэг шалтгаан эзэлж байна.


Улсын хэмжээнд 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 242 тохиолдол бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 110 тохиолдол буюу 45.4 хувь нь, 132 тохиолдол буюу 54.6 хувь нь хөдөө орон нутгаас бүртгэгдсэн байна.


Улаанбаатар хотод 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 110 тохиолдол бүртгэгдсэний 68.2 хувь буюу 75 тохиолдол нь Улаанбаатар хотын харьяат, 31.8 хувь буюу 35 тохиолдол нь хөдөө орон нутгаас ирж энджээ.

Улаанбаатар хотын харьяаллын 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 75 тохиолдлын 58.7 хувь нь эрэгтэй, 41.3 хувь нь эмэгтэй хүүхэд эзэлж байна. Үүнээс эмнэлэгт 66.7 хувь нь, гэрээр 33.3 хувь нь эндсэн байна.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгааныг 2014 онтой харьцуулахад төрөх тойрны перинаталь үеийн эмгэг 3.0 хувиар нэмэгдсэн бол гадны шалтгаант нас баралт 0.4 хувиар, мэдрэлийн тогтолцооны өвчин 1.6 хувиар, төрөлхийн гажиг 2.2 хувиар, амьсгалын замын өвчлөл 0.1 хувиар тус тус буурсан байна.


Зураг 3.8.4. Нялхсын эндэгдлийн тэргүүлэх шалтгаан хувиар, 2014-2015 он



Зураг 3.8.5. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан, хувиар, 2014-2015 он

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 110 тохиолдол бүртгэгдсэн нь амьд төрсөн 1000 хүүхдэд харьцуулахад 2.64 болж өмнөх оноос 0.24 промилиор буурсан байна.

Улаанбаатар хотод 5-19 насны хүүхдийн эндэгдлийн 165 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 2-оор нэмэгдсэн ба үүнээс Улаанбаатар хотын харьяаллын 129 тохиолдол буюу 78.2 хувийг эзэлж байна.

Зураг 3.8.6. 5-19 насны хүүхдийн эндэгдэл, бодит тоо, дүүргээр, 2013-2015 он

10-19 насны өсвөр насны хүүхдийн нас баралтын 136 тохиолдол бүртгэгдсэн ба 102 буюу 75.0 хувийг УБ хотын харьяаллын хүүхэд эзэлж байна. УБ хотын харьяалалтай өсвөр насны хүүхдийн эндэгдлийн 102 тохиолдлоос нь 59 буюу 57.8 хувь нь гадны шалтгаант нас баралт эзэлж байгаа нь өмнөх оноос 6 тохиолдол буюу 10.2 хувиар буурсан байна.

Өсвөр насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаанд сүүлийн жилүүдэд бэртэл хордлого, гадны шалтгаант өвчлөл, эндэгдэл тэргүүлэх байранд орсоор байна.

10-14 насны 10000 хүүхэд тутмын 2.2 нь осол гэмтлээр эндсэн нь өмнөх оноос 1.2-оор, 15-19 насны 10000 хүүхэд тутмын 4.4 нь эндсэн нь өмнөх оноос 2.4-өөр буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 3.8.7. Өсвөр насны хүүхдийн ослын шалтгаант нас баралт, хувиар, нас барсан хэлбэрээр, 2013-2015 он



Өсвөр үеийнхний дотор амиа хорлох, бусад осол, зам тээврийн ослоор дийлэнх нь нас барсан нь тулгамдсан асуудлын нэг хэвээр байсаар байна.

Хүснэгт 3.8.3. Өсвөр үеийнхний гадны шалтгаант эндэгдлийн тэргүүлэх шалтгаан, хувиар, 2012-2015 он

Нас барсан хэлбэр	2012		2013		2014		2015	
	Бодит тоо	Хувь	Бодит тоо	Хувь	Бодит тоо	Хувь	Бодит тоо	Хувь
Амиа хорлосон	16	28.07	15	39.47	17	26.15	16	27.11
Бусдад хорлогдсон	5	8.77	2	5.26	2	3.07	1	1.69
Зам тээврийн осол	9	15.78	8	21.05	11	16.92	10	16.94
Бусад осол	26	45.61	12	31.57	33	50.76	28	47.45
Тодорхой бус			1	2.63	1	1.53	2	3.38
Үйлдвэрийн осол	1	1.75			1	1.53	2	3.38
Нийт	57/100%		38/100%		65/100%		59/100%	

10-19 насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх 5 шалтгаанд бэртэл хордлого, гадны шалтгаант нас баралт 57.8 хувийг, хавдар 6.9 хувь, мэдрэлийн тогтолцооны өвчин 14.7 хувь, яс булчингийн тогтолцооны өвчин 4.9 хувь, халдварт өвчин 3.9 хувийг тус тус эзэлж байна.

3.9. ХҮҮХЭД, ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ӨВЧЛӨЛ

Улаанбаатар хотод бүртгэгдсэн 0-19 насны хүүхдийн нийт 215115 өвчлөл амбулаторт бүртгэгдсэн нь өмнөх оноос 506-аар нэмэгдсэн байна. Нийт өвчлөлөөс УБ хотын харьяаллын хүүхдийн өвчлөлийн 202639 тохиолдол бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн өвчлөлийн 94.2 хувийг эзэлж байна. Хүүхдийн өвчлөлийн насны бүтцийг авч үзэхэд 0-1 хүртэлх насны хүүхдийн өвчлөл 13.9 (28210), 1-4 насны хүүхдийн өвчлөл 36.7 (74496), 5-9 насны хүүхдийн өвчлөл 21.1 (42878), 10-14 насны хүүхдийн өвчлөл 13.5 (27486), 15-19 насны хүүхдийн өвчлөл 14.6 (29569) хувийг тус тус эзэлж байна.

0-1 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд амьсгалын тогтолцооны өвчлөл 68.2, арьс ба арьсан доорхи эслэгийн өвчин 9.6, хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчлөл 5.5, бэртэл хордлого, гадны шалтгаант өвчлөл 3.9, төрөх тойрны (перинаталь) үед үүсэх зарим оёг 3.6 хувийг тус тус эзэлж байна.

1-4 насны хүүхдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд амьсгалын тогтолцооны өвчлөл 58.9, арьс ба арьсан доорхи эслэгийн өвчин 14.3, бэртэл хордлого, гадны шалтгаант өвчлөл 11.7, хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчлөл 7.3, нүд ба түүний дайврын өвчин 2.4 хувийг тус тус эзэлж тэргүүлэх шалтгаан болж байна.

5-9 насны хүүхдийн өвчлөл дотор амьсгалын тогтолцооны өвчлөл 38.7, хоол боловсруулах тогтолцооны өвчлөл 22.3, бэртэл хордлого, гадны шалтгаант өвчлөл 15.9, арьс ба арьсан доорхи эслэгийн өвчин 12.3, чих ба хөхөнцрийн өвчин 3.2 хувиар тэргүүлэх шалтгаанд орж байна.

10-14 насны хүүхдийн өвчлөл дотор амьсгалын тогтолцооны өвчлөл 32.4, бэртэл хордлого, гадны шалтгаант өвчлөл 23.6, хоол боловсруулах тогтолцооны өвчлөл 18.1, арьс ба арьсан доорхи эслэгийн өвчин 13.6, нүд ба түүний дайврын өвчин 3.2 хувиар тэргүүлэх шалтгаанд орж байна.

15-19 насны хүүхдийн өвчлөл дотор амьсгалын тогтолцооны өвчлөл 23.6, бэртэл хордлого, гадны шалтгаант өвчлөл 22.8, арьс ба арьсан доорхи эслэгийн өвчин 18.1, хоол боловсруулах тогтолцооны өвчлөл 15.7, шээс бэлгэсийн тогтолцооны өвчлөл 4.2 хувиар тэргүүлэх шалтгаанд орж байна.

Хүснэгт 3.9.1. Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, тухайн насны 1000 хүүхдэд, 2013-2015 он

Шалтгаан	1 хүртэлх насны хүүхэд			1-4 насны хүүхэд		
	2013	2014	2015	2013	2014	2015
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	33.54	36.99	41.96	41.69	40.96	48.94
Амьсгалын замын тогтолцооны өвчин	401.84	674.53	519.79	322.16	446.30	393.43
Бэртэл хордлого, гадны шалтгаант өвчин	37.79	36.67	29.93	89.02	82.95	78.35
Чих ба хөхөнцрийн өвчин	24.29			12.19	14.71	
Арьс ба арьсан доорхи эслэгийн өвчин	71.21	69.95	73.05	95.38	97.35	95.75
Төрөх тойрны (перинаталь) үед үүсэх зарим оёг		24.81	27.55			
Нүд ба түүний дайврын өвчин						16.24

Хүснэгт 3.9.2. Хүүхэд, өсвөр насны өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 1000 хүүхдэд, 2013-2015 он

Шалтгаан	5-9 нас			10-14 нас			15-19 нас		
	2013	2014	2015	2013	2014	2015	2013	2014	2015
Хоол шингээх боловсруулах тогтолцооны өвчин	54.79	52.70	88.10	36.78	32.26	55.57	37.47	34.20	49.75
Амьсгалын замын тогтолцооны өвчин	99.05	174.81	152.85	94.76	104.22	99.89	69.28	79.91	74.85
Бэртэл хордлого, гадны шалтгаант өвчин	63.27	62.96	63.04	76.38	72.15	72.90	82.63	77.27	72.52
Арьс ба халимны өвчин	50.02	49.34	48.72	43.94	41.08	41.93	59.47	60.52	57.35
Чих ба хөхөнцрийн өвчин	7.42	8.76	12.84	5.94	6.26				
Мэдрэлийн тогтолцооны өвчин							11.04		
Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин								14.39	13.25
Нүд ба түүний дайврын өвчин						10.05			

	тэргүүлэх
	хоёрдугаар
	гуравдугаар

Бүлэг IV. ХАЛДВАРТ ӨВЧИН

4.1. ХАЛДВАРТ ӨВЧИН


Улсын хэмжээнд 2015 онд 29 төрлийн цочмог халдварт өвчний 59400 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 200.5 байна. Өмнөх онтой харьцуулахад 25884 тохиолдлоор буюу 10000 хүн амд 86.1-ээр нэмэгдсэн байна.

Халдварт өвчин нэмэгдсэн нь улаанбурхан өвчний дэгдэлт гарч нийт тохиолдлын 48.8 хувийг эзэлж байгаатай холбоотой.

2015 оны байдлаар Улаанбаатар хотод халдварт өвчний нийт 39925 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 309.5 байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 22315 тохиолдол буюу, 10000 хүн амд 168.3-аар нэмэгдсэн байна.


Энэ онд улаанбурхан өвчний 19427 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 150.5-аар нэмэгдсэн байна.

Зураг 4.1.1. Халдварт өвчний бүтэц, хувиар, 2015 он




Нийт халдварт өвчний 2.2 хувийг вирүст хепатит, 9.9 хувийг гэдэсний халдварт өвчнүүд, 6.3 хувийг сүрьеэ, 58.9 хувийг амьсгалын замын халдварт өвчнүүд, 22.1 хувийг бэлгийн замын халдварт өвчнүүд тус тус эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад амьсгалын замын цочмог халдвар 42.9-өөр нэмэгдсэн бол, вирүст хепатит 1.2-оор гэдэсний халдварт өвчин 11.8, сүрьеэ 8.2, бэлгийн замын халдварт өвчин 21.2, бусад халдварт өвчин 0.7-оор тус тус буурсан байна.

Зураг 4.1.2. Бүртгэгдсэн халдварт өвчин, 10000 хүн амд, 2006-2015 он




Сүүлийн 10 жилийн халдварт өвчний хөдлөл зүйг 2015 онтой харьцуулахад 10000 хүн амд тутамд 120 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Зураг 4.1.3. Зонхилон тохиолдох бэлгийн замын халдварт өвчин, 10000 хүн амд, 2006-2015 он




Зонхилон тохиолдох бэлгийн замын халдварт өвчин 10000 хүн амд харьцуулахад 2015 оны байдлаар улсын дунджаас 35.9-өөр өндөр байна.

Зураг 4.1.4. Зонхилон тохиолдох бэлгийн замын халдварт өвчин, 10000 хүн амд, 2006-2015 он



Зонхилон тохиолдох бэлгийн замын халдварт өвчнийг тус бүрд нь авч үзвэл тэмбүүгийн өвчлөл нийслэлийн хэмжээнд өндөр байна.

Зураг 4.1.5. Гэдэсний халдварт өвчин, 10000 хүн амд, 2006-2015 он



Хүснэгт 4.1.1. Бүртгэгдсэн гэдэсний халдварт өвчний үзүүлэлт, 2014-2015 он

Халдварт өвчин /ӨОУА-10 нэршлээр/	2014		2015		Өсөлт /бууралт/ 10 000 хүн амд
	Бодит тоо	10 000 хүн амд	Бодит тоо	10 000 хүн амд	
Балнад	4	0.03	1	0.01	-0.02
Сальмонеллөз	72	0.58	105	0.81	0.23
Цусан суулга	1921	15.4	2336	18.1	2.7
Хүнсний гаралтай бактерт хордлого	235	1.88	376	2.91	1.03
Цочмог А хепатит	101	0.81	6	0.05	-0.76
Гар хөл амны өвчин	1614	12.94	1205	9.34	-3.6

4.2. БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАР

Зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдварт өвчний 8913 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 69.1 байна. Нийт тохиолдлын 23.8 хувь нь заг хүйтэн, 21.9 хувь нь трихомониаз, тэмбүү 46.6 хувийг нь тэмбүүгийн өвчлөл тус тус эзэлж байна.

Монгол улсад ХДХВ/ДОХ-ын халдварын анхны тохиолдол 1992 онд бүртгэгдсэнээс хойш 2015 оны жилийн эцсийн байдлаар ХДХВ/ДОХ-ын нийт 199 тохиолдол бүртгэгдэж, үүнээс 18 тохиолдол нь 2015 онд шинээр бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн 199 тохиолдлын 27 нь нас барсан байна. Нийт тохиолдлын 159 нь (79.9%) эрэгтэйчүүд, 39 нь (19.6%) эмэгтэйчүүд, 1 тохиолдол (0.5%) хүйс тодорхойгүй хүн байна.

Хүснэгт 4.2.1. Бүртгэгдсэн бэлгийн замаар дамжих халдвар, 2014-2015 он


Халдварт өвчин /ӨОУА-10 нэршлээр/	2014		2015		Өсөлт /бууралт/ 10 000 хүн амд
	Бодит тоо	10 000 хүн амд	Бодит тоо	10 000 хүн амд	
Тэмбүү	3618	29.01	4154	32.18	3.17
Заг хүйтэн	1650	13.23	2122	16.44	3.21
Трихомониаз	1723	13.82	1950	15.11	1.29
ХДХВ/ДОХ	31	0.25	18	0.14	-0.11

2015 онд тэмбүү өвчний 4154 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 32.2 байна. Төрөлхийн тэмбүү өвчний 30 тохиолдол бүртгэгдсэн нь 0.7 хувийг эзэлж байна. Тэмбүү өвчнөөр өвчлөгсдийн 11.3 хувь нь өсвөр насныхан, 78.9 хувь нь 20-39 насны, 10.1 хувийг 40-өөс дээш насны хүмүүс эзэлж байна. Нийгмийн байдлаар авч үзэхэд 32.2 хувь нь ажилгүй, 38.9 хувь нь ажил эрхэлдэг, 11.4 хувь нь оюутнууд байна.

Халдварын эх уурхай нь байнгын бэлгийн хавьтагчаас 58.9%, тохиолдлын бэлгийн хавьтлаас 38.4% нь, биеэ үнэлэгчээс 0.6% нь халдвар авсан байна.

Илрүүлэлтийн хувьд 52.7 хувь нь урьдчилан сэргийлэх, 38.9 хувь нь өвчний учир амбулатори, 1.5 хувь нь диспансерийн хяналтын үзлэгээр илэрчээ. Бүртгэгдсэн тэмбүү өвчний 34.4 хувийг жирэмсэн эмэгтэйчүүд эзэлж байгаа нь өмнөх оноос 1.2 хувиар буурсан байна.

Зураг 4.2.1. Шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах тэмбүү өвчний тархалт, хувиар, 2006-2015 он



Шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах тэмбүү өвчний тархалт 2015 оны байдлаар 2006 оноос хойш дунджаар 2.1 пунктээр өссөн байна.

Хүснэгт 4.2.2. Жирэмсэн эмэгтэйчүүдийн ийлдэс судлалын шинжилгээнд хамрагдалт, 2015 он

№	Үзүүлэлт		2015
1	Тэмбүү илрүүлэх хурдавчилсан шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо	Нийт	36511
		Анх удаа хамрагдсан	25117
		Давтан хамрагдсан	11394
2	Тэмбүү илрүүлэх хурдавчилсан шинжилгээ эерэг гарсан жирэмсэн эмэгтэйн тоо		1199
3	RPR, TPHA шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэй тоо		1262
4	Жирэмсэн эмэгтэйчүүдээс шинээр илэрсэн тэмбүү		1092
5	Илрүүлсэн хавьтагчийн тоо		874
6	Тэмбүү илрүүлэх хурдавчилсан шинжилгээнд хамруулсан хавьтагчийн тоо		603
7	Тэмбүүгийн хурдавчилсан шинжилгээ эерэг гарсан хавьтагчийн тоо		351
8	RPR, TPHA шинжилгээнд хамрагдсан хавьтагчийн тоо		622
9	Хавьтагчаас шинээр илэрсэн тэмбүү		340
10	Эмчилгээний эхний тун авсан	Нийт	1805
		Жирэмсэн эмэгтэйн тоо	1207
		Хавьтагчийн тоо	598
11	Бүрэн эмчлэгдсэн	Нийт	1632
		Жирэмсэн эмэгтэйн тоо	1080
		Хавьтагчийн тоо	552
12	Эмчилгээний явцад гаж нөлөө өгсөн жирэмсэн эмэгтэйн тоо		2
13	Дахин халдвар авсан жирэмсэн эмэгтэйн тоо		0

Хавьтагчийн илрүүлэлт нийслэлд 80.1 хувьтай байгаа ба илэрсэн хавьтагчдын дунд 40.1 хувьд нь шинэ тэмбүү илэрсэн байна.

Хүснэгт 4.2.3. Амаржих газруудын үзүүлэлт, 2015 он

№	Ангилал	Үзүүлэлт	2015
1	Тэмбүү илрүүлэх хурдавчилсан шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо	Нийт	84
		Жирэмсний хяналтанд ороогүй	47
		Хожуу үеийн зулбалт /13-21 долоо хоног/	9
		Дутуу төрөлт /22-с дээш долоо хоног/	5
		Амьгүй төрөлт	7
		Давтан шинжилгээнд хамрагдаагүй, шинжилгээний дүгнэлт байхгүй	16
2	Тэмбүү илрүүлэх хурдавчилсан шинжилгээнд эерэг гарсан	Жирэмсний хяналтанд ороогүй	6
		Хожуу үеийн зулбалт /13-21 долоо хоног/	4
		Дутуу төрөлт /22-с дээш долоо хоног/	0
		Амьгүй төрөлт	2
		Давтан шинжилгээнд хамрагдаагүй, шинжилгээний дүгнэлт байхгүй	4
3	Эмчилгээ онош баталгаажилт, зөвлөгөө	Эмчилгээний эхний тун авсан	16
		RPR баталгаажуулах шинжилгээ хийсэн	8
		Зөвлөгөө өгч, БЗДХ-ын эмчид мэдээлсэн эхний тоо	9
4	Төрөлхийн тэмбүүтэй төрсөн хүүхдийн тоо	Нийт	1
		Амьд	1
		Нас барсан	0
5	Төрөлхийн тэмбүүтэй хүүхэд төрсөн шалтгаан	Тэмбүү өвчнийг илрүүлж эмчлүүлээгүй	0
		Эмчилгээ хийлгэсэн боловч үр дүнгүй	0

Амаржих газруудад 84 жирэмсэн эмэгтэйг тэмбүүгийн хурдавчилсан оношлуурт хамруулсанаас 17.9 хувьд нь сорил эерэг гарсан ба 100 хувь эмчилгээний эхний тунг хийсэн. Амаржих газрууд холбогдох дүүргийн БЗДХ-ын эмч нартай үйл ажиллагаагаа уялдуулан ажиллаж байна.

Заг хүйтэн өвчний 2122 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 16.4 байна. Өмнөх онтой харьцуулахад 10000 хүн амд 3.2-оор нэмэгдсэн байна. Нийгмийн байдлын хувьд 39.1 хувь нь ажил эрхэлдэггүй хүмүүс, 39.3 хувь нь ажил эрхэлдэг, 18.4 хувь нь оюутнууд эзэлж байна.

Трихомониазын халдварын 1950 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 15.1 байна. Өмнөх онтой харьцуулахад өвчлөл 10000 хүн ам тутмад 1.3-аар нэмэгдсэн байна. Халдварын эх уурхай байнгын бэлгийн хавьтагчаас 59.7 хувь нь, тохиолдлын бэлгийн хавьтлаас 25.7 хувь нь халдвар авсан байна.

Трихомониазын халдвар 20-39 насныханд дийлэнх хувийг эзэлж байгаа ба нийгмийн байдлаар нь авч үзэхэд ажил эрхэлдэг хүмүүс 34.0 хувийг, ажил эрхэлдэггүй хүмүүс 50.3 хувийг, оюутнууд 14 хувийг эзэлж байна.

4.3. ГЭДЭСНИЙ ХАЛДВАР

2015 онд Улаанбаатар хотод гэдэсний халдварт өвчин 4023 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 181 тохиолдлоор нэмэгдсэн байна. Гэдэсний халдварт өвчний дотор цусан суулга 58.1, хоолны хордлого 9.4, сальмонеллёз 2.6, гар хөл амны өвчин 29.9 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 4.3.1. Бүртгэгдсэн гэдэсний халдварт өвчний бүтэц, хувиар, 2015 он



Цусан суулга өвчний 2336 тохиолдол буюу 10000 хүн амд 18.1 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2.7-оор өссөн байна. Дүүргүүдээр харьцуулахад: Налайх, Багануур, Багахангай дүүргүүдээс бусад дүүргүүдэд хотын дунджаас өндөр байна.

Улаанбаатар хотод бүртгэгдсэн нийт өвчлөлийн 30.1 хувь нь Баянзүрх, 22.7 хувь нь Сонгинохайрхан, 12.1 хувь нь Чингэлтэй, 14.1 хувь нь Баянгол, 10.2 хувь нь Сүхбаатар, 9.2 хувь нь Хан-Уул, 0.6 хувь нь Налайх, 0.6 хувь нь Багануур, 0.4 хувь нь Багахангай дүүрэгт тус тус бүртгэгдсэн байна. Цусан суулга өвчний 95.0 хувь нь эмнэл зүйгээр, 0.1 хувь нь нян судлалын шинжилгээгээр, 4.7 хувь нь эмнэл зүй, нян судлалын шинжилгээгээр, 0.2 хувь нь бусад шинжилгээгээр тус тус онош тогтоогдсон байна. Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн цусан суулга өвчний халдварыг эх уурхайгаар нь авч үзэхэд 7.4 хувь нь өвчтөнөөс, 0.1 хувь нь нян тээгчээс, 92.5 хувь нь тогтоогдоогүй байна. Халдвар дамжсан зам нь 10.2 хувь нь ахуйн хавьтлаар, 89.8 хувь нь эх уурхай тодорхойгүй байна.

Сальмонеллёзын халдвар

Улсын хэмжээнд сальмонеллёзын халдварын нийт 146 тохиолдол бүртгэгдсэний 71.9 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Улаанбаатар хотод сальмонеллёзын өвчлөл 10000 хүн амд 0.8 байгаа нь өмнөх оноос 10000 хүн ам тутамд 0.2-оор нэмэгдсэн байна.


Гар хөл амны өвчин

Улсын хэмжээнд гар хөл амны өвчний 1524 тохиолдол бүртгэгдсэний 84.1 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Улаанбаатар хотод гар хөл амны өвчлөл 10000 хүн амд 9.1 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 3.6-аар буурсан байна. Улсын хэмжээнд гар хөл амны өвчний 87.8 хувийг 0-9 насны хүүхдийн өвчлөл эзэлж байна.

Вирүст гепатитын өвчлөл

Улаанбаатар хотод вирүст гепатитын 523 тохиолдол бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10000 хүн амд 4.0 байна. (Улсын хэмжээнд 892 тохиолдол буюу 10000 хүн амд 3.0 байна) Өнгөрсөн онтой харьцуулахад 80 тохиолдлоор буурч, нийт тохиолдлын 16.8 хувийг вирүст гепатит А, 51.7 хувийг вирүст гепатит В, 13.8 хувийг вирүст гепатит С, 17.7 хувийг бусад вирүст гепатит тус тус эзэлж байна.


Зураг 4.3.2. Вирус хепатит, 10000 хүн амд, 2006-2015 он



4.4. АМЬСГАЛЫН ЗАМЫН ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН


2015 онд Улаанбаатар хотод амьсгалын замын халдварт өвчний 23725 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 20852 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Зураг 4.4.1. Амьсгалын замын цочмог халдварт өвчлөлийн бүтэц, хувиар, 2015 он



Амьсгалын замын цочмог халдварт өвчний 81.8 хувийг улаанбурхан, 14.2 хувийг салхинцэцэг, 2.7 хувийг улаан эсэргэнэ, 0.8 хувийг гахай хавдар үлдсэн хувийг бусад өвчлөл эзэлж байна.


Зураг 4.4.2. Амьсгалын замын цочмог халдварт өвчин, 10000 хүн амд, 2014-2015 он



Гахай хавдар


Улсын хэмжээнд гахай хавдар өвчний 241 тохиолдол бүртгэгдсний 66.0 (n=159) хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. 10000 хүн амд 1.2 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 29 тохиолдол буюу 10000 хүн амд 0.3-аар буурсан байна.

Зураг 4.4.3. Гахай хавдар өвчин, насны бүлгээр, хувиар, 2015 он



Гахай хавдар өвчний нийт тохиолдлын дийлэнх буюу 89.6 хувь нь 0-19 насныхан, 10.5 хувийг 20-39 насны хүмүүст бүртгэгдсэн байна.


Зураг 4.4.4. Гахай хавдар өвчний хөдлөл зүй, сараар, бодит тоо, 2014-2015 он



Салхинцэцэг өвчин


Улсын хэмжээнд салхинцэцэг өвчний 5624 тохиолдол бүртгэгдсний 59.2 (n=3329) хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Улаанбаатар хотод өвчлөлийн 3329 тохиолдол бүртгэгдсэн ба өмнөх онтой харьцуулахад 10000 хүн амд 7.3-аар нэмэгдсэн байна.

Зураг 4.4.5. Салхинцэцэг өвчний хөдлөл зүй, сараар, бодит тоо, 2015 он



Улиралчлал: Салхинцэцэгийн өвчлөл нь 1 сард ихэсч, 2 сард бага зэрэг буурч, 3 сараас 6 сар хүртэл ихэсч, 7 сараас буурч дахин 10 сараас ихэсч байна.

Зураг 4.4.6. Салхинцэцэг өвчин, насны ангиллаар, хувиар, 2015 он



Насны бүтцээр авч үзэхэд 81.5 хувь нь 0-15 насны хүүхэд байгаа бол үүнээс 32.7 хувь нь гэртээ, 26.2 хувь нь сургуулийн, 41.1 хувь нь цэцэрлэгийн хүүхдүүд байна.

Менингококкын халдвар

Улаанбаатар хотод менингококкт халдварын 6 тохиолдол бүртгэгдсэн нь улсын хэмжээнд бүртгэгдсэн менингококкт халдварын 54.5 хувийг эзэлж байгаа ба өмнөх оноос 1 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Сүрьеэ

Улсын хэмжээнд сүрьеэ өвчний нийт 4270 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 7.2 хувийг эзэлж байна. Улаанбаатар хотод өвчлөлийн 2534 тохиолдол байгаа нь сүрьеэгийн нийт өвчлөлийн 59.3 хувийг эзэлж байна. Улаанбаатар хотод 2015 онд 10000 хүн ам ногдох өвчин 18.5 байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс өндөр байна.

Эмэнд тэсвэртэй сүрьеэ:

Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн өвчлөл жил бүр нэмэгдсээр байгаа ба 2015 онд улсын хэмжээнд эмэнд тэсвэртэй сүрьеэ (ЭТС)-ийн 278 тохиолдол бүртгэгдсэн ба үүнээс 174 тохиолдол буюу 62.6% нь УБ хотоос бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн тохиолдлуудаас дүүргээр авч үзэхэд БГД, БЗД, СХД, СБД, ХУД, ЧД-үүдэд ЭТС-ийн өвчлөл өндөр байна.

Эмчилгээнд орсон эмэнд тэсвэртэй сүрьеэтэй 278 өвчтөний 158 (56,8%) эрэгтэй, 120 (43,2%) эмэгтэй, хүйсийн харьцаа 1.3:1 байна. 2013 онд олон эмэнд тэсвэртэй сүрьеэ (ОЭТС)-ийн 212 тохиолдол эмчилгээнд хамрагдсан. Эдгээрээс 3 тохиолдол одоо эмчилгээ нь үргэлжилж байгаа тул нийт 209 өвчтөний эмчилгээний үр дүнг тооцоход эмчилгээний амжилт 62.2% байна.

Улаанбаатар хотод сүрьеэгийн шинэ тохиолдол 2534 бүртгэгдсэн нь улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт шинэ сүрьеэгийн дотор 59.4 хувийг эзэлж, урьд оны мөн үетэй харьцуулахад 24 тохиолдлоор буурсан байна. Бүртгэгдсэн нийт шинэ тохиолдлын 54.7 хувийг уушигны сүрьеэ, 45.3 хувийг уушигны бус эрхтний сүрьеэ эзэлж байгаа ба хүүхдийн өвчлөл 462 тохиолдол бүртгэгдсэн нь 18.23 хувийг эзэлж байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад уушгины сүрьеэ 282 тохиолдол буюу 10.5 хувиар буурч, уушгины бус эрхтний сүрьеэ 257 тохиолдол буюу 10.5 хувиар нэмэгджээ. Ойрын хавьтал 3854 хүн үзлэгт хамрагдахаас 2972 буюу 77.0 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна.

Үзлэгт хамрагдсан хүнээс 83 нь буюу 2.8 хувь нь сүрьеэгээр өвчилж сүрьеэгийн эмчилгээнд хамрагдсан, хавьтал 170 хүүхдэд туберкулины сорил хэт өндөр гарч 60 хүүхэд буюу нийт үзлэгт хамрагдсан хүний 2.1 хувь нь сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамрагдсан байгаа нь насанд хүрэгчдийн хавьтлын өвчлөл урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамрагдалтаас илүү өндөр байна.


Шинээр илэрсэн сүрьеэтэй өвчтөний 66.3 хувийг 16-44 насныхан эзэлж байгаа нь залуу хөдөлмөрийн насны хүмүүс илүүтэй өвчилж байгааг харуулж байна. Хүйсийн хувьд 54.9 хувийг эрэгтэйчүүд, 45.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Хүснэгт 4.4.1. Бүртгэгдсэн сүрьеэ өвчин, дүүргүүдээр, 2014-2015 он

Дүүрэг	2014		2015		“Өсөлт /бууралт”
	Бодит тоо	10 000 хүн амд	Бодит тоо	10 000 хүн амд	10 000 хүн амд
Баянгол	344	17.5	346	16.9	-0.6
Баянзүрх	644	21.5	580	18.9	-2.6
Сонгинохайрхан	627	23.3	594	20.7	-2.6
Сүхбаатар	234	17.6	216	16	-1.6
Хан-Уул	231	17.9	267	19.8	1.9
Чингэлтэй	289	18.7	333	21.1	2.4
Налайх	61	18.5	54	15.9	-2.6
Багануур	34	12.3	38	13.5	1.2
Багахангай	6	16	11	28.5	12.5
Бусад эмнэлгүүд	74	-	95	-	-
Улаанбаатар	2544	20.4	2534	19.7	-0.7

2015 онд 10000 хүн амд ногдох өвчлөл Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Багахангай дүүргүүдэд нийслэлийн дундаж үзүүлэлтээс өндөр байна.

Зураг 4.4.7. Сүрьеэ өвчин, 10000 хүн амд, 2006-2015 он




Улаанбурхан

Улсын хэмжээнд улаанбурхан өвчний 23464 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 79.2 байна. Улаанбаатар хотод нийт тохиолдлын 82.8 (n=19427) хувь нь бүртгэгдэж 10000 хүн амд 150.5 байна. Тухайн насны 10000 хүн амд ногдох өвчлөл 0-4 насны хүүхдийн 237.9, 5-9 насны хүүхдийн 46.3, 10-14 насны хүүхдийн 100.0, 15-19 насны хүүхдийн 597.3, 20-24 насны хүн амын 394.4, 25-29 насны хүн амын 125.0, 30-34 насны хүн амын 86.7, 35-аас дээш насанд 18.1 байна.

Хүснэгт 4.4.2. Улаанбурхан өвчний тохиолдол, нас баралт, улсын дүнгээр


Он	Өвчлөл	Нас баралт
2001	10677	7
2002	2105	3
2003	18	0
2004-2005	0	0
2006-2009	72	0
2010-2014	0	0
2015	23464	8
2016	15540	59

Зураг 4.4.8. Улаанбурхан өвчний хөдлөл зүй, сараар, 2015 он




Улиралчлал:

Улаанбурхан өвчин нь 2015 оны 3 сард анхны тохиолдол бүртгэгдэж 6 сард дээд тохиолдол буюу 55.4 (n=10755) хувь нь бүртгэгдсэн байна.

Зураг 4.4.9. Улаанбурхан өвчин, насны ангиллаар, хувиар, 2015 он

Насны хувьд хамгийн өндөр буюу 27.9 хувь нь 15-19 насны хүн ам, 22.5 хувь нь 20-24 насны хүн ам байна.

Зураг 4.4.10. Улаанбурхан өвчний тархвар зүйн хандлага /2015-2016 он, нийслэл/

2015 онд улаанбурхан өвчний дэгдэлт гарсантай холбоотой УГУ вакциныг товлот болон нэмэлт дархлаажуулалтыг хийсэн ба товлот дархлаажуулалтын 1-р тун 97.7 хувь, 2-р тун 97.5 хувьтай байна. Нэмэлт дархлаажуулалтыг 2015 оны 05 сарын 15-наас 25-ны хооронд зохион байгуулж 06 сартайгаас 6 хүртэлх насны хүн амыг зорилтот бүлэг болгон дархлаажуулсан ба хамрагдалтын хувь 89.5 байна.

Бүлэг V. ХАЛДВАРТ БУС ӨВЧЛӨЛ

5.1. ХҮН АМЫН НИЙТ ӨВЧЛӨЛ

Монгол Улс халдварт бус өвчний эрсдлийг бууруулах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй зонхилон тохиолддог халдварт бус өвчний хяналт, тандалтыг сайжруулах зорилгоор 2014 оны Засгийн газрын 34 дүгээр тогтоолоор “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хоёр дахь хөтөлбөрийг баталсан.

Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын шаталсан судалгаа үндэсний хэмжээнд 5 удаа хийгдэж 2013 онд хийгдсэн сүүлийн судалгааны үр дүнгээр артерийн даралт ихсэлтийн тархалт нийт хүн амын дунд 27.5 хувь байсан бөгөөд артерийн гипертензийн тархалт байршлын хувьд хот хөдөөд ижил түвшинд байна. Эрэгтэйчүүдийн дундах артерийн даралт ихсэлтийн тархалт (30.5%) эмэгтэйчүүдээс (24.5%) илүү байна. Судалгааны насны нийт хүн амын 61.9 хувь цусан дахь холестерин хэмжээ ихэссэн, цусан дахь триглицеридын хэмжээ 19.6 хувь байсан нь энэхүү эрсдэлийн тархалт эрэгтэйчүүдэд (22.4%) эмэгтэйчүүдээс (17.1%) илүү байгааг харуулсан.¹

Халдварт бус өвчнөөр өвчлөх өндөр эрсдэлтэй буюу нийтлэг тохиолдох 5 эрсдэлт хүчин зүйлсээс 3-5 эрсдэл хавсран илэрсэн аль ч насны эрэгтэйчүүдийн (35.2%) эзлэх хувь тухайн ижил насны эмэгтэйчүүдийн үзүүлэлтээс их байгаа нь монгол эрчүүдийн дундаж наслалт болон амьдралын чанарт сөргөөр нөлөөлж байна.


Албан ёсны статистик мэдээгээр улсын хэмжээнд халдварт бус өвчлөлийн 2315399 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 7649.5 байгаа бол Улаанбаатар хотод өвчлөлийн 1000931 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 7754.6 байна.

Хүснэгт 5.1.1 Хүн амын нийт өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10000 хүн амд

Өвчний бүлэг	Улс	Улаанбаатар
Амьсгалын тогтолцооны өвчин	1462.7	1484.6
Хоол шингээх эрхтний өвчин	1202.8	1089.9
Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	931.2	809.4
Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	783.7	659.5
Бэртэл хордлого, гадны шалтгаант өвчин	534.6	803.9

Улаанбаатар хотод хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд бэртэл хордлого гадны шалтгаант өвчлөл улсын дунджаас өндөр буюу 10000 хүн амд 169.3-аар буюу 1.5 дахин их байна.

¹ Эх сурвалж: Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын шаталсан судалгаа, Монгол улс-2013

Зураг 5.1.1. Хүн амын нийт өвчлөл, 10000 хүн амд, 2006-2015 он, Улаанбаатар хот**Зураг 5.1.2.** Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10000 хүн амд, 2006-2015 он

Амьсгалын тогтолцооны өвчлөл сүүлийн жилүүдэд тогтмол тэргүүлэх шалтгаан болсоор байгаа ба өмнөх оноос 10000 хүн амд 115.0-аар буурсан хэдий ч сүүлийн 5 жилийн дунджаас 398.1-ээр нэмэгдсэн байна. Нийт өвчлөгсдийн 52.7 хувь нь эмэгтэйчүүд, 47.3 хувь нь эрэгтэйчүүд эзэлж, өвчлөлийн 47.2 хувь нь 0-5 хүртэлх насны хүүхдүүд эзэлж байгаа нь өмнөх оноос 4.8 хувиар буурсан байна.

Амьсгалын тогтолцооны өвчний дотор амьсгалын замын цочмог өвчин 119466 тохиолдол буюу 62.3 хувийг /10000 хүн амд 925.5/, уушгины хатгалгаа 21598 тохиолдол буюу 11.3 хувийг /10000 хүн амд 167.3/ тус тус эзэлж байна.

Хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчин 10000 хүн амд 1089.8 байгаа нь өмнөх оноос 138.3-аар нэмэгдсэн байна. Хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчний дотор ходоод, гэдэсний өвчин 22514 тохиолдол буюу 16.0 хувь /10000 хүн амд 174.4/, элэгний өвчин 25114 тохиолдол буюу 17.9 хувийг /10000 хүн амд 194.6/ тус тус эзэлж байна.

Цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл 2001 оноос хойш байнга нэмэгдэж байгаа ба нас баралтын тэргүүлэх шалтгаан болсоор байна. 2014 онтой харьцуулахад 10000 хүн амд ногдох цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл 37.1-ээр буурсан үзүүлэлттэй

байна. Цусны эргэлтийн тогтолцооны өвчний дотор цусны даралт ихсэх өвчин 42034 тохиолдол буюу 40.2 хувь /10000 хүн амд 325.7/, зүрхний ишемийн өвчнүүд 23034 тохиолдол буюу 22.0 хувийг /10000 хүн амд 174.4 / эзэлж байна.


2015 онд нийслэлийн хүн амын 10000 хүн тутмын 803.9 нь осол гэмтэлд өртсөн нь тулгамдсан асуудал болж байгаа бөгөөд нас баралтын тэргүүлэх шалтгаан болсоор байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад осол гэмтлийн өвчлөл 10000 хүн амд 28.2-оор, сүүлийн 5 жилийн дунджаас 21.0-ээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Өвчлөгсдийн 61 хувийг эрэгтэйчүүд эзэлж, 20-30 насны хүмүүс осол гэмтэлд илүү өртөж байна. Түлэгдэлтийн 60.1 хувийг 5 хүртэлх насны хүүхэд эзэлж байна.

Зураг 5.1.3. Бүртгэгдсэн осол гэмтлийн өвчлөл, шалтгаанаар, 2015 он



Зураг 5.1.4. Осол гэмтлийн өвчлөл, 10000 хүн амд, дүүргээр, 2015 он



Артерийн гипертензи, чихрийн шижингийн өвчлөл

Цусны даралт ихсэх өвчин /артерийн гипертензи/ нийт халдварт бус өвчлөлийн 4.0 хувийг эзэлж 10000 хүн амд 218.0 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 20.0-оор буурсан байна. Хүйсийн хувьд 64.8 хувь нь эмэгтэй, 35.2 хувь нь эрэгтэйчүүд эзэлж байна. Насны бүлгээр нь авч үзэхэд 45-64 насанд дийлэнх буюу 17139 тохиолдол бүртгэгдсэн нь /61 хувь/ тухайн насны 10000 хүн амд 770.7 байгаа нь өмнөх оноос 28.3-аар, харин 65-аас дээш насанд 1388.7 байгаа нь өмнөх оноос 392.7-оор тус тус

буурсан байна. Цусны даралт ихсэх өвчний шинэ тохиолдол 7748 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 3110-аар буурсан байна.

Чихрийн шижин өвчин нийт халдварт бус өвчний дотор 1.2 хувийг эзэлж, 10000 хүн амд 62.3 байгаа нь өмнөх оноос 28.1-ээр буурсан байна. Хүйсийн хувьд эрэгтэйчүүдэд 10000 хүн амд 59.1, эмэгтэйчүүдэд 65.2 байна. Насны бүлгээр авч үзэхэд 45-64 насныханд 5115 тохиолдол /63.5 хувь/ бүртгэгдсэн нь тухайн насны 10000 хүн амд 230.0 болж өмнөх оноос 78-аар буурсан байна. Чихрийн шижин өвчний шинэ тохиолдол 1552 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 77-оор буурсан байна.

Хүснэгт 5.1.2. Хүн амын нийт өвчлөлийн үзүүлэлт, өвчний ангиллаар, 2015 он

№	Дүүрэг		Халдварт өвчин	Хавдар	Цус, цус төлжүүлэх эрхтний өвчин	Дотоод шүүрэл, бодисын солилцооны өвчин	Сэтгэцийн ба зан төрхийн эмгэг	Мэдрэлийн тогтолцооны өвчин	Нүд ба түүний дайрын өвчин	Чих ба хөхлөг сэртэнгийн өвчин	Зүрх судасны тогтолцооны өвчин	Амьсгалын тогтолцооны өвчин
1	Баянгол	Бодит тоо	7168	5386	359	4517	2391	11719	7851	1407	19309	37135
		10000 хүн амд	350.5	263.3	17.6	220.8	116.9	573.0	383.9	68.8	944.1	1815.6
2	Баянзүрх	Бодит тоо	14302	8474	523	3498	3344	13673	4633	2584	21277	46597
		10000 хүн амд	466.6	276.5	17.1	114.1	109.1	446.1	151.2	84.3	694.2	1520.3
3	Сонгинохайрхан	Бодит тоо	11516	6989	386	3602	2584	12265	9374	4294	19649	21181
		10000 хүн амд	401.9	243.9	13.5	125.7	90.2	428.0	327.1	149.8	685.7	739.1
4	Сүхбаатар	Бодит тоо	5604	4086	328	2435	1808	7245	6624	1785	14921	38391
		10000 хүн амд	415.5	303.0	24.3	180.6	134.1	537.2	491.2	132.4	1106.4	2846.8
5	Хан-Уул	Бодит тоо	4549	3348	260	2345	1549	4738	2456	1268	9777	11131
		10000 хүн амд	337.6	248.5	19.3	174.0	115.0	351.7	182.3	94.1	725.7	826.2
6	Чингэлтэй	Бодит тоо	6183	4052	258	3451	1774	5706	3861	1998	13710	15809
		10000 хүн амд	392.1	257.0	16.4	218.9	112.5	361.9	244.9	126.7	869.4	1002.6
7	Налайх	Бодит тоо	1187	1304	113	264	294	1696	289	1008	2657	3700
		10000 хүн амд	350.2	384.8	33.3	77.9	86.7	500.4	85.3	297.4	784.0	1091.7
8	Багануур	Бодит тоо	824	969	104	468	241	3105	2407	1879	2772	17441
		10000 хүн амд	292.9	344.4	37.0	166.3	85.7	1103.6	855.5	667.9	985.2	6199.0
9	Багахангай	Бодит тоо	71	68	0	38	22	48	39	13	400	240
		10000 хүн амд	184.2	176.4	0.0	98.6	57.1	124.5	101.2	33.7	1037.6	622.6
	Бүгд	Бодит тоо	51404	34676	2331	20618	14007	60195	37534	16236	104472	191625
		10000 хүн амд	398.2	268.6	18.1	159.7	108.5	466.4	290.8	125.8	809.4	1484.6

Хүснэгт 5.1.3. Хүн амын нийт өвчлөлийн үзүүлэлт, өвчний ангиллаар, 2015 он

№	Дүүрэг		Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин	Шээс бэлгийн тогтолцооны эмгэг	Жирэмсэн төрөлт терсний дараах үе	Перинаталь үед үүссэн зарим эмгэг	Төрөлхийн гажиг, гаж хөгжил	Өөр бүлэгт ангилаагүй шинж тэмдэг	Гэмтэл хордлого гадны шалтгаан	Бүгд
1	Баянгол	Бодит тоо	27119	10909	5264	15383	4047	834	520	56	16689	183459
		10000 хүн амд	1325.9	533.4	257.4	752.1	197.9	40.8	25.4	2.7	816.0	8969.7
2	Баянзүрх	Бодит тоо	27502	17454	8906	20101	6193	1011	719	86	22552	231207
		10000 хүн амд	897.3	569.5	290.6	655.8	202.1	33.0	23.5	2.8	735.8	7543.5
3	Сонгинохайрхан	Бодит тоо	33723	12833	6786	16973	5222	1016	798	75	26216	203747
		10000 хүн амд	1176.8	447.8	236.8	592.3	182.2	35.5	27.8	2.6	914.8	7109.9
4	Сүхбаатар	Бодит тоо	13559	9993	3229	10764	3360	456	312	112	12624	141407
		10000 хүн амд	1005.4	741.0	239.4	798.2	249.1	33.8	23.1	8.3	936.1	10485.5
5	Хан-Уул	Бодит тоо	11160	5543	2735	8036	3277	632	290	23	10815	88416
		10000 хүн амд	828.3	411.4	203.0	596.4	243.2	46.9	21.5	1.7	802.7	6562.3
6	Чингэлтэй	Бодит тоо	17025	9177	3909	8366	3684	543	565	45	11875	116365
		10000 хүн амд	1079.7	582.0	247.9	530.5	233.6	34.4	35.8	2.9	753.1	7379.5
7	Налайх	Бодит тоо	4381	2050	1179	2036	545	107	77	16	1384	25253
		10000 хүн амд	1292.7	604.9	347.9	600.7	160.8	31.6	22.7	4.7	408.4	7451.2
8	Багануур	Бодит тоо	5998	1994	777	3144	571	207	117	57	1434	45184
		10000 хүн амд	2131.9	708.7	276.2	1117.5	203.0	73.6	41.6	20.3	509.7	16059.7
9	Багахангай	Бодит тоо	209	67	78	323	45	2	3	2	171	1913
		10000 хүн амд	542.2	173.8	202.3	837.9	116.7	5.2	7.8	5.2	443.6	4962.4
	Бүгд	Бодит тоо	140676	70020	32863	85126	26944	4790	3202	452	103760	1000931
		10000 хүн амд	1089.9	542.5	254.6	659.5	208.7	37.1	24.8	3.5	803.9	7754.6

Хүснэгт 5.1.4. Хүн амын нийт өвчлөлийн шалтгаан, хүйсээр, 2015 он

Өвчний бүлэг ОУА-10 Main Causes	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд
Халдварт ба шимэгчт зарим өвчин	51404	398.3	24928	405.1	26476	392.0
Хавдар	34676	268.7	11061	179.7	23615	349.7
Цус, цус бүтээх эрхтний өвчин ба дархланы механизм хамарсан зарим	2331	18.1	832	13.5	1499	22.2
Дотоод шүүрэл тэжээлийн ба бодисын солилцооны өвчнүүд	20618	159.7	7284	118.4	13334	197.4
Сэтгэцийн ба аягийн эмгэг	14007	108.5	7439	120.9	6568	97.3
Мэдрэлийн тогтолцооны өвчин	60195	466.4	21855	355.1	38340	567.7
Нүд ба түүний дайврын өвчнүүд	37534	290.8	13879	225.5	23655	350.3
Чих ба хөхөнцрийн өвчин	16236	125.8	6782	110.2	9454	140.0
Цус эргэлтийн тогтолцооны өвчин	104472	809.4	40786	662.8	63686	943.0
Амьсгалын тогтолцооны өвчин	191625	1484.6	90572	1471.8	101053	1496.3
Хоол шингээх эрхтний өвчин	140676	1089.9	55386	900.0	85290	1262.9
Арьс ба халимны өвчин	70020	542.5	29065	472.3	40955	606.4
Яс булчингийн тогтолцоо-ны холбох нэхдэсний өвчнүүд	32863	254.6	10171	165.3	22692	336.0
Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	85126	659.5	17544	285.1	67582	1000.7
Жирэмслэх, төрөх, төрсний дараах үе	26944	208.7	0	0.00	26944	208.7
Төрөх тойрны (перинатал) үед үүсэх зарим оёг	4790	37.1	2740	44.5	2050	30.4
Төрөлхийн гажиг хэв гажил, өнгөт цогцын гажуудал	3202	24.8	1441	23.4	1761	26.1
Хаа ч ангилаагүй хам шинж, тэмдэг эмнэлзүйн ба лабораторийн шинжилгээний гажуу үзүүлэлтүүд	452	3.5	213	3.5	239	3.5
Бэртэл, хордлого ба бусад зарим гадны шалтгааны үр дагавар	103760	803.9	63210	1027.2	40550	600.4
НИЙТ ДҮН	1000931	7754.6	405188	6584.2	595743	8821.1

5.2. ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛ

Улаанбаатар хотод 2319 тохиолдол бүртгэгдсэн ба 100 000 хүн амд харьцуулахад 173.3 байгаа нь өмнөх оноос 8.1-ээр, сүүлийн 5 жилийн дунджаас 12.7-оор нэмэгдсэн байна.


Хорт хавдрын өвчлөлийн дотор элэгний өмөн, ходоодны өмөн, умайн хүзүүний өмөн, уушгины өмөн, улаан хоолойн өмөн хорт хавдрын тэргүүлэх шалтгаан болж байна.

НЭМГ-ын харьяа дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд шинээр бүртгэгдсэн хорт хавдрын өвчлөл 917 буюу 10000 хүн амд 7.1 байгаа нь өмнөх оны мөн үеэс 112 тохиолдол буюу 1.6-аар буурсан байна.

Шинээр хяналтанд орсон өвчтөний 20.8 хувь нь I, II үе шатанд оношлогдсон ба өмнөх оноос 1.5 хувиар нэмэгдсэн байна. 79.2 хувь нь хожуу оношлогдсон байгаа нь өмнөх оноос 3.2 хувиар нэмэгдсэн байна. 5-аас дээш жил амьдарч буй өвчтөний эзлэх хувь 33.9 байна.

Хорт хавдрын улмаас хяналтанд байгаа хүн амын 24 хувь нь уг өвчнөөр нас барсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 2.1 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зураг 5.2.1. Шинээр бүртгэгдсэн хорт хавдрын өвчлөл, 100 000 хүн амд, 2006-2015 он



Хүснэгт 5.2.1. Зонхилон тохиолдох хорт хавдар, хувиар, 2006-2015 он

Өвчний ангилал	Он									
	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Элэг	45.0	48.7	59.5	59.8	58.5	36.6	27.0	23.8	20.0	36.1
Ходоод	22.6	19.5	26.4	26.3	24.2	14.4	32.9	12.9	14.0	14.6
Уушиг	9.6	8.6	13.3	10.6	11.4	9.9	16.0	14.9	13.1	5.7
Улаан хоолой	10.2	8.0	9.9	8.3	9.0	7.5	12.2	4.9	7.6	5.5
Умайн хвзvv	15.4	11.4	14.4	7.9	15.0	5.2	16.5	12.7	14.0	10.2
Бүгд	137.8	146.3	165.1	153.3	156.8	167.7	151.5	162.0	165.2	179.6

Хүснэгт 5.2.2. Улаанбаатар хотод шинээр бүртгэгдсэн хорт хавдрын өвчлөл, өвчний ангиллаар, дүүргээр, 2015 он

№	Дүүрэг	Уруул амьны хөндийн	Улаан хоолой	Ходоодны хорт хавдар	Бүдүүн гэдэс	Шулуун гэдэс	Элэг	Нойрхой	Төвөнх	Уушги	Амьсгал ба цээжний хөндийн эрхтний бүсэд	Яс	Ye ба үений мөгөөрсний бүсэд	Арсны меланома	Арсны бүсэд	Хөх	Умайн хүзүү
1	Баянгол	Бодит тоо 10000 хүн амд	3	15	46	13	4	117	9	0	22	0	1	1	5	22	30
			0.15	0.73	2.25	0.64	0.20	5.72	0.44	0.0	1.08	0.0	0.05	0.05	0.24	1.08	1.47
2	Баянзүрх	Бодит тоо 10000 хүн амд	4	26	83	8	4	197	10	2	25	3	1	1	2	32	61
			0.13	0.85	2.71	0.26	0.13	6.43	0.33	0.07	0.82	0.10	0.03	0.03	0.07	1.04	1.99
3	Багануур	Бодит тоо 10000 хүн амд	0	3	6	1	1	23	4	0	6	0	0	0	1	7	7
			0.0	1.07	2.13	0.36	0.36	8.17	1.42	0.0	2.13	0.0	0.0	0.0	0.36	2.49	2.49
4	Чингэлтэй	Бодит тоо 10000 хүн амд	0	14	54	5	2	101	8	2	14	0	0	0	3	10	28
			0.0	0.89	3.42	0.32	0.13	6.41	0.51	0.13	0.89	0.0	0.06	0.0	0.19	0.63	1.78
5	Сүхбаатар	Бодит тоо 10000 хүн амд	1	12	29	3	1	101	5	0	15	2	1	0	0	10	22
			0.07	0.89	2.15	0.22	0.07	7.49	0.37	0.0	1.11	0.15	0.07	0.0	0.0	0.74	1.63
6	Сонгинохайрхан	Бодит тоо 10000 хүн амд	2	37	72	19	4	171	16	3	34	2	1	1	2	17	35
			0.07	1.29	2.51	0.66	0.14	5.97	0.56	0.10	1.19	0.07	0.17	0.03	0.07	0.59	1.22
7	Хан-Уул	Бодит тоо 10000 хүн амд	0	14	25	11	2	76	17	1	10	2	1	1	1	27	37
			0.0	1.04	1.86	0.82	0.15	5.64	1.26	0.07	0.74	0.15	0.07	0.07	0.07	2.00	2.75
8	Налайх	Бодит тоо 10000 хүн амд	0	1	13	5	2	22	3	1	1	1	1	0	0	5	6
			0.0	0.30	3.84	1.48	0.59	6.49	0.89	0.3	0.3	0.3	0.3	0.0	0.0	1.48	1.77
9	Багахангай	Бодит тоо 10000 хүн амд	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	2
			0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	5.19
Нийт		Бодит тоо 10000 хүн амд	10	122	328	65	20	808	72	9	127	10	6	11	4	14	228
			0.08	0.95	2.54	0.5	0.15	6.26	0.56	0.07	0.98	0.08	0.05	0.09	0.03	0.11	1.77

Эх сурвалж: Хавдар судлалын үндэсний төв

Хүснэгт 5.2.3. Улаанбаатар хотод шинээр бүртгэгдсэн хорт хавдрын өвчлөл, өвчний ангиллаар, дүүргээр, 2015 он

№	Дүүрэг	Умайн	Өндгөвчний	Шодой	Түрүү бүлчирхай	Төмсөг	Бөөр	Давсаг	Анхдагч байрлал тодорхойгүй хавдар	Амьсгалын ба хоол боловсруулах эрхтний хоёрдогч хавдрууд	Тархины	Ходжкнины лимфома	Ходжкны бус лимфома	Лейкеми	Лимфолейкеми
1	Баянгол	Бодит тоо	1	11	1	2	8	3	1	0	3	0	4	3	3
		10 000 хүн амд	0.05	0.54	0.05	0.05	0.10	0.39	0.15	0.05	0.0	0.15	0	0.20	0.15
2	Баянзүрх	Бодит тоо	1	9	1	3	14	7	3	1	3	1	4	3	6
		10 000 хүн амд	0.03	0.29	0.03	0.10	0.10	0.46	0.23	0.10	0.03	0.10	0.03	0.13	0.10
3	Багануур	Бодит тоо	0	0	0	0	1	0	0	0	0	0	1	1	0
		10 000 хүн амд	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.36	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.36	0.36
4	Чингэлтэй	Бодит тоо	1	6	1	1	4	0	0	0	4	0	1	3	0
		10 000 хүн амд	0.06	0.38	0.06	0.06	0	0.25	0.0	0.0	0.25	0.0	0.06	0.19	0.19
5	Сүхбаатар	Бодит тоо	1	3	0	0	7	0	1	0	4	0	0	2	1
		10 000 хүн амд	0.07	0.22	0.0	0.0	0.0	0.52	0.0	0.07	0.30	0.0	0.0	0.15	0.15
6	Сонгинохайрхан	Бодит тоо	2	8	0	1	10	4	1	1	8	1	3	3	1
		10 000 хүн амд	0.07	0.28	0.0	0.03	0.07	0.35	0.14	0.03	0.28	0.03	0.10	0.10	0.10
7	Хан-Уул	Бодит тоо	1	4	0	2	10	5	0	0	6	0	2	2	2
		10 000 хүн амд	0.07	0.30	0.0	0.15	0.15	0.74	0.37	0.0	0.45	0.0	0.15	0.15	0.15
8	Налайх	Бодит тоо	0	2	0	1	2	0	1	0	1	0	0	0	1
		10 000 хүн амд	0.0	0.59	0.0	0.3	0.0	0.59	0.0	0.30	0.30	0.0	0.0	0.0	0.0
9	Багахангай	Бодит тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
		10 000 хүн амд	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
	Нийт	Бодит тоо	7	43	3	9	56	19	7	2	29	2	15	17	14
		10 000 хүн амд	0.05	0.33	0.02	0.07	0.07	0.43	0.15	0.05	0.02	0.22	0.02	0.12	0.13

Эх сурвалж: Хавдар судлалын үндэсний төв

5.2.4. Улаанбаатар хотод бүртгэгдсэн хорт хавдрын нас баралт, өвчний ангиллаар, дүүргээр, 2015 он

№	Дүүрэг	Хүний амын хөндийн																													
		Бодит тоо	1	0	0	0	1	10	29	Ходоод	Нарийн гэдэс	Бүдүүн гэдэс	Шүлүүн гэдэс	Элэг	Цус, элэгний гаднах	Нойрхой	Хамрын дайвар	Хөндийн	Төвөнх	Уушги	Амьсгал ба цээжний	Хөндийн эрхтний	Бусад хавдрууд	Яс	Үе ба үеийн	Мөгөөрсний бусад	Захын мэдрэл ба	автомат мэдрэлийн	Хэвлийн гялтаа ба	Гялтгангийн арьс зайн	
1	Баянгол	Бодит тоо	10 000 х/а	0.05	0.0	0.0	0.0	0.05	0.49	1.42	0.0	0.34	0.1	3.08	0.05	0.34	0.0	0.0	0.0	0.0	1.03	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.05	0.1	0.1	
2		Баянзүрх	Бодит тоо	10 000 х/а	0.0	1	2	2	18	66	0	9	1	140	2	7	0	0	0	0	0	29	3	1	2	1	3	0.10	0.0	0.10	0.0
3	Багануур		Бодит тоо	10 000 х/а	0.0	0	0	0	4	5	0	0	1	18	0	4	0	0	0	0	3	0	0	0	0	0	0	0	0	0	0
4		Чингэлтэй	Бодит тоо	10 000 х/а	0.0	0.0	0.0	0.0	1.42	1.78	0.0	0.0	0.36	6.4	0.0	1.42	0.0	0.0	0.0	0.0	1.07	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
5	Сүхбаатар		Бодит тоо	10 000 х/а	0.0	0	1	0	13	28	1	2	3	90	0	7	2	1	15	0	0	2	1	0	0	0	0	0	0.06	0.0	0.0
6		Сонгинохайрхан	Бодит тоо	10 000 х/а	0.07	0.15	0.3	0.0	0.44	1.48	0.22	0.22	0.07	5.41	0.0	0.3	0.0	0.0	0.0	0.0	0.89	0.07	0.07	0.07	0.07	0.07	0.07	0.0	0.0	0.0	0.0
7	Хан-Уул		Бодит тоо	10 000 х/а	0.07	0.03	0.03	0.0	0.91	1.99	0.03	0.42	0.14	4.89	0.1	0.38	0.03	0.03	0.0	0	11	1	1	1	3	0	2	0.0	0.0	0.07	0.07
8		Налайх	Бодит тоо	10 000 х/а	0.0	2	1	0	9	23	0	6	0	57	3	14	0	0	0	0	11	1	1	1	0	0	0	0	0	0	0
9	Багахангай		Бодит тоо	10 000 х/а	0.0	0.15	0.07	0.0	0.67	1.71	0.0	0.45	0.0	4.23	0.22	1.04	0.0	0.0	0.0	0.82	0.07	0.07	0.07	0.07	0.07	0.07	0.07	0.07	0.07	0.07	0.07
Нийт			Бодит тоо	10 000 х/а	0.0	0	0	0	2	9	0	5	0	24	0	1	0	0	0	0	5	1	1	1	0	0	0	0	0	0	0
	Бодит тоо		10 000 х/а	0.0	0.0	0.0	0.0	0.59	2.66	0.0	1.48	0.0	7.08	0.0	0.3	0.0	0.3	0.0	0.0	1.5	0.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
		Бодит тоо	10 000 х/а	0.0	0	0	0	0	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
		Бодит тоо	10 000 х/а	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	2.59	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
	Нийт	Бодит тоо	5	6	9	3	88	237	5	44	12	606	9	55	4	3	122	7	4	8	3	7	0.05	0.03	0.06	0.02	0.05	0.02	0.05	0.02	0.05
		10 000 х/а	0.04	0.05	0.07	0.02	0.68	1.84	0.04	0.34	0.09	4.69	0.07	0.43	0.03	0.02	0.95	0.05	0.03	0.02	0.95	0.05	0.03	0.06	0.02	0.05	0.02	0.05	0.02	0.05	0.05

Эх сурвалж: Хавдар судлалын үндэсний төв

Хүснэгт 5.2.5. Улаанбаатар хотод бүртгэгдсэн хорт хавдрын нас баралт, өвчний ангиллаар, дүүргээр, 2015

№	Дүүрэг	Холбох эдийн, арьсан доорхи, зөөлөн эдийн	Арьсны бусад	Хөх	Эм бэлгийн их уруулын	Үрэжний	Умайн хүзүү	Умайн	Өндгөвчний	Трүү булчирхай	Төмсөг	Бөөр	Давсаг	Анхдагч байрлал тодорхойгүй хавдар	Тунгалийн зангилаанд байршсан хавдар	Амьсгалын ба хоол боловсруулах эрхтний	Тархины	Ходжкнины бус лимфома	Лейкеми	Лимфогейкеми
1	Баянгол	Бодит тоо 10 000 х/а	0	2	8	0	1	9	1	5	0	3	0	0	0	1	3	3	2	2
2	Баянзүрх	Бодит тоо 10 000 х/а	0.1	0.1	0.39	0.0	0.0	0.44	0.05	0.24	0.0	0.15	0.0	0.0	0.0	0.0	0.15	0.15	0.1	0.1
3	Багануур	Бодит тоо 10 000 х/а	0.1	0.07	0.36	0.0	0.0	0.55	0.0	0.23	0.07	0.2	0.07	0.07	0.07	0.0	0.07	0.13	0.07	0.03
4	Чингэлтэй	Бодит тоо 10 000 х/а	0	0	1	0	0	3	0	0	0	1	0	0	0	0	0	0	1	0
5	Сүхбаатар	Бодит тоо 10 000 х/а	0.06	0.06	0.25	0.0	0.0	0.51	0.06	0.25	0.06	0.19	0.0	0.0	0.0	0.0	0.19	0.13	0.13	0.0
6	Сонгинохайрхан	Бодит тоо 10 000 х/а	0	0	4	0	0	6	0	3	0	3	0	1	0	0	3	1	2	1
7	Хан-Уул	Бодит тоо 10 000 х/а	0.03	0.07	0.1	0.0	0.0	0.52	0.03	0.24	0.03	0.10	0.10	0.03	0.07	0.03	0.07	0.0	0.07	0.07
8	Налайх	Бодит тоо 10 000 х/а	0	0	0.37	0.07	0.0	0.89	0.0	0.15	0.15	0.07	0.07	0.0	0.0	0.0	0.45	0.15	0.07	0.0
9	Багахангай	Бодит тоо 10 000 х/а	0	0	0	0	0	4	0	2	1	0	1	1	0	0	0	0	0	0
	Нийт	Бодит тоо 10 000 х/а	0.05	0.05	0.28	0.02	0.02	0.57	0.02	0.23	0.05	0.15	0.05	0.04	0.03	0.02	0.15	0.09	0.09	0.06

Эх сурвалж: Хавдар судлалын үндэсний төв

5.3. ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ҮЗЛЭГ

Улсын хэмжээнд артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт 362325 хүн хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 65.1 хувийг эзэлж байна. Хамрагдалтыг өмнөх онтой харьцуулахад 23.5 хувиар нэмэгдсэн байна.

Нийслэлийн хэмжээнд артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт 136283 хүн хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 44.5 хувийг хамруулсан ба 2.8 хувьд нь артерийн гипертензи оношлогдсон байна.

Улсын хэмжээнд чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт 335912 хүн хамрагдсан нь хамрагдвал зохих хүн амын 60.3 хувийг эзэлж байна. Үр дүнгийн үзүүлэлтээр 3.2 хувьд нь чихрийн шижин өвчин оношлогдсон байна.

Улаанбаатар хотод чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт 120456 хүн хамрагдсан нь хамрагдвал зохих хүн амын 39.3 хувийг эзэлж байна. Үр дүнгийн үзүүлэлтээр 0.6 хувьд нь чихрийн шижин өвчин оношлогдсон байна.

Хүснэгт 5.3.1. Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь, 2015 он

№	Дүүрэг	Артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэг		Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлэг	
		Хамрагдсан хувь	Онош батлагдсан хувь	Хамрагдсан хувь	Онош батлагдсан хувь
1	Баянгол	43.8	0.3	43	0.1
2	Баянзүрх	41.4	1.6	36.2	0.7
3	Сонгинохайрхан	42.4	6.7	32.9	1.6
4	Сүхбаатар	25.6	5.7	23.9	1.4
5	Хан-уул	44.1	2.5	32.1	0.2
6	Чингэлтэй	43.4	1.4	71.6	0.4
7	Багануур	59	0.8	75.4	0.1
8	Налайх	9.2	1.0	9.2	0.0
9	Багахангай	51.6	1.1	47.4	0.0
10	Жаргалант	49.3	2.9	49.3	0.0
11	Хонхор	68.8	18.9	68.8	0.9
12	Туул	12.5	0.0	12.5	0.0
13	Улаанбаатар	44.5	2.8	39.3	0.6
14	Улсын дүн	65.1	3.5	60.3	3.2

Умайн хүзүү, хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэг

Улсын хэмжээнд умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэгт зорилтот насны нийт 72851 эмэгтэй (38.8 хувь) хамрагдаж, урилга хүлээн авсан үйлчлүүлэгчдээс 69.5 хувь нь эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан байна.

Хамрагдсан үйлчлүүлэгчдийн 10296 (13 хувь) нь пап сорил эерэг буюу умайн хүзүүний эсийн түвшинд өөрчлөлттэй гарсан. Үүнээс умайн хүзүүний өмөнгийн 78 шинэ тохиолдол илэрч бүртгэгдсэн байна.

Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт энэ онд зорилтот болон зорилтот бус насны нийт 21981 эмэгтэй хамрагдсан ба хамрагдвал зохих насны 19678 эмэгтэйчүүд (29.3) хамрагджээ. Харин урилга хүлээн авсан 35593 үйлчлүүлэгчдээс 61.7 хувь нь эрт

илрүүлгийн үзлэгт хамрагдсан. Нийт хамрагдагсдын 1285 (5.8 хувь) нь пап сорил эерэг буюу умайн хүзүүний эсийн түвшинд өөрчлөлттэй гарсан. Умайн хүзүүний өмөнгийн 27 шинэ тохиолдол бүртгэгдсэн байна.

Хөхний эрт илрүүлэг үзлэгт 52032 эмэгтэй хамрагдсан ба 176 эмэгтэй хөхний эмнэл зүйн үзлэгээр эерэг буюу хөхөндөө бэрсүү, үүсгэвэртэй байсан. Уг үзлэгийн хүрээнд хөхний өмөнгийн өндөр эрсдэлтэй бүлгийн 44 эмэгтэй хамрагдсан байна. Хөхний өмөнгийн 5 шинэ тохиолдол оношлогджээ.

Хүснэгт 5.3.2. Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдалтын хувь, 2015 он

№	Дүүргийн нэр	Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг		Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг	
		Зорилтот насны бүлэг	Зорилтот насны бүлгийн эмэгтэйчүүдийн илрүүлэг үзлэгт хамрагдсан хувь	Боломжит илрүүлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо	Боломжит илрүүлэгт хамрагдсан хувь
1	Баянгол	3856	34.9	6281	56.9
2	Баянзүрх	4209	27.1	23246	100.0
3	Сонгинохайрхан	2676	19.6	3109	22.8
4	Сүхбаатар	2273	33.7	3016	44.7
5	Хан-Уул	1999	25.1	4650	58.4
6	Чингэлтэй	3193	37.1	8157	94.9
7	Налайх	206	11.0	346	18.4
8	Багануур	1253	88.1	2959	100
9	Багахангай	13	5.2	268	100
10	Улаанбаатар	19678	29.3	52032	77.6
11	Улсын дүн	72851	38.8	226304	87.8

5.4. СТАЦИОНАРЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсдийн өвчлөл

Улсын хэмжээнд 2015 оны байдлаар эмнэлэгт 784891 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлж 5778348 ор хоног ашигласан бөгөөд дундаж ор хоног 7.4 байна.

Хүснэгт 5.4.1 Стационарын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10000 хүн амд, 2015 он

Өвчний ангилал	Улс	Улаанбаатар
Амьсгалын тогтолцооны өвчин	415.7	353.0
Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	384.8	352.9
Хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчин	324.3	350.7
Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	302.8	261.5
Мэдрэлийн тогтолцооны өвчин	169.5	183.3

2015 онд Улаанбаатар хотын ор бүхий эмнэлэгт нийт 384489 хүн хэвтэн эмчлэгдэн 2842749 ор хоног ашигласан бөгөөд ор ашиглалтын хувь 86.5, дундаж ор хоног 7.4, орны эргэлт 38.6 байна. Нийт стационарын өвчлөлд Улаанбаатар хотын харьяаллын иргэдийн өвчлөл 80.7 хувийг эзэлж байна. Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа болон бусад мэдээ өгдөг ор бүхий эмнэлгүүдэд 242519.5 хүн хэвтэн эмчлэгдэн 1593499 ор хоног ашигласан бөгөөд ор ашиглалтын хувь 79.7, дундаж ор хоног 6.6, орны эргэлт 40.1 байна.

Зураг 5.4.1 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ төрлөөр, 2015 он



2015 онд стационарын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болж буй амьсгалын тогтолцооны өвчлөлөөр эмчлүүлэгсдийн 57.2 хувь нь Тав хүртэлх насны хүүхдүүд байна.

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгааны дотор зонхилж буй өвчнүүдийг авч үзвэл:

- ✓ Шээс бэлгэсийн тогтолцооны өвчний дотор бөөрний сувганцрын үрэвсэлт өвчин 56.4 хувь
- ✓ Амьсгалын тогтолцооны өвчний дотор уушигны хатгалгааны улмаас хэвтэн эмчлүүлэгчид 36.2 хувь
- ✓ Хоол боловсруулах тогтолцооны өвчний дотор элэгний эмгэг өвчин 30.8 хувь
- ✓ Зүрх судасны өвчний дотор цусны даралт ихсэх өвчин 39.2 хувь, зүрхний ишеми өвчин 22.8 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 5.4.2. Стационарын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, 10000 хүн амд

Тэргүүлэх шалтгаан	2011 он		2012 он		2013 он		2014 он		2015 он	
	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй
Хоол шингээх эрхтний өвчин	379.2	345.0	313.0	314.5	338.5	338.0	329.3	330.0	352.9	356.4
Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	364.9	394.2	346.4	379.8	340.1	372.6	339.5	366.1	350.7	383.7
Амьсгалын тогтолцооны өвчин	363.8	376.3	377.5	343.7	356.6	330.2	426.7	396.1	353.0	383.7
Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	278.3	387.9	232.0	326.8	238.0	343.8	250.4	364.4	261.5	381.4
Мэдрэлийн тогтолцооны өвчин	182.4	197.7	165.6	183.2	161.2	181.8	199.0	184.8	183.2	212.2


Хүснэгт 5.4.3. Амбулатори, стационарын өвчлөлийн бүтэц, 10000 хүн амд, 2015 он

№	Өвчний ангилал	Амбулаторийн өвчлөл		Үүнээс: Эмэгтэй		Стационарын өвчлөл		Үүнээс: Эмэгтэй	
		Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд
1	Халдварт ба шимэгчт зарим өвчин	38470	298.0	19722	292.0	12934	100.2	6754	100.0
2	Хавдар	26162	202.7	18146	268.7	8514	66.0	5469	81.0
3	Цус, цус бүтээх эрхтний өвчин ба дархлааны механизм хамарсан зарим	1161	9.0	819	12.1	1170	9.1	680	10.1
4	Дотоод шүүрэл тэжээлийн ба бодисын солилцооны өвчнүүд	14692	113.8	9984	147.8	5926	45.9	3350	49.6
5	Сэтгэцийн ба аягийн эмгэг	7309	56.6	3857	57.1	6698	51.9	2711	40.1
6	Мэдрэлийн тогтолцооны өвчин	36542	283.1	24006	355.5	23653	183.2	14334	212.2
7	Нүд ба түүний дайврын өвчнүүд	33965	263.1	21656	320.7	3569	27.7	1999	29.6
8	Чих ба хөхөнцрийн өвчин	14575	112.9	8498	125.8	1661	12.9	956	14.2
9	Цус эргэлтийн тогтолцооны өвчин	59211	458.7	37775	559.3	45261	350.7	25911	383.7
10	Амьсгалын тогтолцооны өвчин	146067	1131.6	79667	1179.6	45558	353.0	21386	316.7
11	Хоол шингээх эрхтний өвчин	95126	737.0	61220	906.5	45550	352.9	24070	356.4
12	Арьс ба халимны өвчин	62259	482.3	36813	545.1	7761	60.1	4142	61.3
13	Яс булчингийн тогтолцооны холбох нэхдэсний өвчнүүд	18593	144.0	12951	191.8	14270	110.6	9741	144.2
14	Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	51376	398.0	41821	619.2	33750	261.5	25761	381.4
15	Жирэмслэх, төрөх, төрсний дараах үе	1014	7.9	1014	15.0	25930	200.9	61950	917.3
16	Төрөх тойрны (перинатал) үед үүсэх зарим оёг	1013	7.8	437	6.5	3777	29.3	1613	23.9
17	Төрөлхийн гажиг хэв гажил, өнгөт цогцын гажуудал	1536	11.9	868	12.9	1666	12.9	893	13.2
18	Хаа ч ангилаагүй хам шинж, тэмдэг эмнэлзүйн ба лабораторийн шинжилгэний гажуу үзүүлэлтүүд	317	2.5	173	2.6	135	1.0	66	1.0
19	Бэртэл, хордлого ба бусад зарим гадны шалтгааны үр дагавар	91054	705.4	35906	531.7	12706	98.4	4644	68.8
20	НИЙТ ДҮН	700442	5426.6	415333	6149.8	300489	2328.0	216430	3204.6


Нийслэлийн хэмжээд эмнэлгийн нас баралтын 2668 тохиолдол бүртгэгдсэний 18.1 хувь нь НЭМГ-ын харьяа ор бүхий эмнэлэгт, 2.3 хувь нь НЭМГ-т мэдээ өгдөг бусад эмнэлэгт, 0.2 хувь нь хувийн эмнэлэгт, 79.4 хувь нь ЭМСЯ-ны харьяа эмнэлгүүдэд бүртгэгджээ. Хоног болоогүй 481 нас баралтын 66.8 хувь нь ЭМСЯ-ны харьяа ор бүхий эмнэлгүүдэд, 27.6 хувь нь НЭМГ-ын харьяа ор бүхий эмнэлэгт, 5.6 хувь нь НЭМГ-т мэдээ өгдөг бусад эмнэлэг, хувийн эмнэлгүүдэд бүртгэгдсэн байна.

НЭМГ-ын харьяа болон НЭМГ-т мэдээ өгдөг бусад эмнэлгүүдэд нийт 552 эмнэлгийн нас баралт бүртгэгдсэний 160 буюу 28.9 хувь нь хоног болоогүй нас баралт, үүнээс 80 буюу 50 хувь нь 8-24 цагийн дотор нас барсан байна.

Зураг 5.4.2. Стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2006-2015 он



Зураг 5.4.3. Орны үзүүлэлт, 2006-2015 он



Бүлэг VI. ХҮН АМЫН НАС БАРАЛТ


Улсын хэмжээнд 2015 оны жилийн эцсийн байдлаар нас баралтын 16374 тохиолдол бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 121 тохиолдлоор буюу 0.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 6.1. Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан, 10000 хүн амд

Өвчний ангилал	Улс	Улаанбаатар
Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	18.5	15.1
Хавдар	13.2	12.1
Осол гэмтэл, гадны шалтгаан	8.5	8.8
Хоол шингээх эрхтний өвчин	4.3	4.4
Амьсгалын тогтолцооны өвчин	2.0	2.0

Улаанбаатар хотод нас баралтын 7405 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 184 тохиолдлоор буюу 2.4 хувиар буурсан байна. Нас барсан хүний 59.9 хувь нь эрэгтэй, 40.1 хувь нь эмэгтэй байна. Нийт нас баралтын 48.0 хувь нь ЭМСЯ-ны харьяа улсын болон хувийн хэвшлийн эмнэлэгт, 52.0 хувь нь НЭМГ-т мэдээ өгдөг улсын болон хувийн хэвшлийн эмнэлэгт бүртгэгдсэн байна.

Зураг 6.1. Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан, 10000 хүн амд, УБ, 2006-2015 он



Зураг 6.2. Хүн амын нас баралт, нас барсан газраар, 2015 он

Нас барсан хүний 81.4 хувь нь өвчний улмаас, 18.6 хувь нь осол гэмтлийн улмаас нас барсан байна. Улаанбаатар хотод эмнэлгийн нас баралтын 2668 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 179 тохиолдлоор нэмэгдсэн байна. Улаанбаатар хотын харьяалалтай иргэдийн нас баралтын 30.4 хувийг эмнэлгийн нас баралт эзэлж байна.


Зураг 6.3. Хүн амын нас баралт 10000 хүн амд, шалтгаан, хүйсээр

Цусны эргэлтийн тогтолцооны өвчлөлийн шалтгаант нас баралт хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон хэвээр байна. 2015 онд цусны эргэлтийн тогтолцооны өвчлөлийн шалтгаант нас баралт 10000 хүн амд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3-аар буурч нийт нас баралтын 30.7 хувийг эзэлж байна. Цусны эргэлтийн тогтолцооны өвчлөлийн нас баралтанд тархинд цус харвалт, тархины архаг цус хомсролт өвчин, зүрхний цочмог шигдээс, даралт ихсэх өвчний шалтгаант нас баралт дийлэнх хувийг эзэлж байна.

Хорт хавдрын шалтгаант нас баралт хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болсоор байгаа ба 2015 оны байдлаар нийт нас баралтын 24.6 хувийг эзэлж байна. Үүнд элэгний өмөн, ходоодны өмөн, уушигны өмөн, улаан хоолойн өмөн, умайн хүзүүний өмөн сүүлийн жилүүдэд тэргүүлэх шалтгаан болж байна.


Осол гэмтлийн шалтгаант нас баралт сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод нэмэгдэж нийт нас баралтын тэргүүлэх шалтгаанд орсоор байна. 2015 онд гадны шалтгаант нас баралтын 1365 тохиолдол бүртгэгдсэн нь нийт нас баралтын 18.4 хувийг эзэлж байна.

Зураг 6.4. Осол гэмтлийн шалтгаант нас баралт, 10000 хүн амд, дүүргээр, 2015 он



Налайх болон Багахангай дүүрэгт осол гэмтлийн шалтгаант нас баралт Улаанбаатар хотын үзүүлэлтээс өндөр буюу 10000 хүн амд Налайх дүүрэгт 5.9, Багахангай дүүрэгт 6.8-аар илүү байна.

Зураг 6.5. Осол гэмтлийн нас баралт, хэлбэрээр, 2015 он



Осол гэмтлийн гадны шалтгаант нас баралтын дийлэнх хувийг зам тээврийн осол, амиа хорлох, бусад осол эзэлж байна. Бусад осол дотор архины хордлого сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байгаа ба 2015 оны байдлаар бусад ослын шалтгаант нас баралтын 48 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 5.5-аар, хөлдөлт ба осгож нас барсан хүмүүс осол гэмтлийн нас баралтын 10.5 хувь байгаа нь өмнөх оноос 0.2-оор нэмэгдсэн байна.

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 114 тохиолдол буюу 10.0 хувийг бага насны хүүхдийн нас баралт эзэлж байна. Хүүхдийн осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 25 тохиолдол буюу 21.9 хувь нь түлэгдэлт эзэлж байна.

Бүлэг VII. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Монгол улсын эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлгийн тусламж үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрддэг.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь дараах 2 төрөлтэй байна. Үүнд:

- ✓ Нийгмийн эрүүл мэндийн
- ✓ Эмнэлгийн тусламж үйлчилгээ

Эрүүл мэндийн тухай хуулинд хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ нь хүн бүрт жигд, хүртээмжтэй хүмүүнлэг, энэрэнгүй ёс, шинжлэх ухааны мэдлэг ололт, нотолгоо, орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны дэвшилтэт аргад тулгуурласан байна гэж заасан байдаг.²

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага дараах төрөлтэй байна. Үүнд: өрхийн эрүүл мэндийн төв; сум, тосгоны эрүүл мэндийн төв; сум дундын эмнэлэг; клиник; амаржих газар; нийгмийн эрүүл мэндийн төв; нэгдсэн эмнэлэг; сувилал; түргэн тусламжийн төв; бүсийн оношлогоо, эмчилгээний төв; төв эмнэлэг; тусгай мэргэжлийн төв.

2015 оны байдлаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 3244 эрүүл мэндийн байгууллага байгаа бөгөөд төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв-13, бүсийн оношлогоо эмчилгээний төв-5, аймгийн нэгдсэн эмнэлэг-16, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв-12, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг-6, тосгоны эрүүл мэндийн төв-19, сумын ЭМТ-272, сум дундын эмнэлэг-39, өрхийн ЭМТ-218, бусад эмнэлэг-96, хувийн ортой эмнэлэг 224, клиник эмнэлэг 1006 эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байна.³

Хүснэгт 7.1. Эрүүл мэндийн байгууллагууд тусламж үйлчилгээний шатлалаар, 2015

Эрүүл мэндийн байгууллагууд	Тоо
Өрхийн эрүүл мэндийн төв	218
Сум / тосгоны эрүүл мэндийн төв	272/19
Сум дундын эмнэлэг	39
Дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв	12
Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	6
Аймгийн нэгдсэн эмнэлэг	16
Бүсийн оношлогоо эмчилгээний төв	5
Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд	13
Амаржих газрууд	3
Ортой хувийн эмнэлгүүд	224
Үүдэн /клиник/ хувийн эмнэлэг	1006
Аршаан сувилал, сувилал	105
Эм ханган нийлүүлэх байгууллага	210
Эмийн үйлдвэр	33
Хувийн эмийн сан	967
Бусад /ЭМСЯ, ЭМХТ, НЭМХ, АУХ, Анагаах ухааны сургууль, коллеж, хилийн цэрэг Батлан хамгаалах, төмөр замын эмнэлэг гэх мэт/	96
Бүгд	3244

² Эрүүл мэндийн тухай хууль, 2011

³ Эрүүл мэндийн үзүүлэлт, 2015, ЭМХТ

Нийслэлийн хүн амд өрхийн эрүүл мэндийн төв 129, тосгоны эрүүл мэндийн төв 5, нэгдсэн эмнэлэг 4, дүүргийн эрүүл мэндийн төв 8, төв эмнэлэг 13, амаржих газар 3, бусад эмнэлгүүд 19, ор бүхий хувийн эмнэлэг 85, сувилал 69, клиник 638, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр, эмийн сан 508 нийт 1475 байгууллага эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.⁴

7.1. ӨРХ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага юм.

АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Эрүүл мэндийн салбарын хөгжил 2” хөтөлбөрийн хүрээнд өрхийн эмнэлгүүдийг Улаанбаатар хот болон бүх аймгийн төвүүдэд үе шаттайгаар байгуулж, 2002 он гэхэд өрхийн эмнэлгийн тогтолцоонд шилжсэн билээ.

Эрүүл мэндийн тухай хуулинд зааснаар иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх зорилгоор өрхийн нэг эрүүл мэндийн төвд ногдох иргэний тоог нийслэлд 8000-аас доошгүй, аймаг, суурин газарт 6000-аас доошгүй байхаар зааж, нэг өрхийн эрүүл мэндийн төвд ногдох иргэний нийт тоо 14.000-аас хэтрэхгүй байхаар тогтоосон байна.

Зураг 7.1.1. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй өрхийн ЭМТ-ийн байршил



2015 оны байдлаар Улаанбаатар хотын 129 өрхийн эрүүл мэндийн төв, 13 салбарт 376.4 мян өрхийн 1.345.5 мян хүн ам бүртгэлтэй байна.

Бүртгэлд хамрагдсан өрхийн 48.6 хувь нь эрүүл, 36.9 хувь нь бага өртөмтгий, 14.5 хувь нь өвчлөлд өртөмтгий бүлгийн өрхүүд байна.

Нийслэлийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 622 их эмч, 577 сувилагч болон нийт 1674 ажиллагсад хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Нийт ажиллагсдын 87.8 хувь нь эмэгтэйчүүд байна.

⁴ Эрүүл мэндийн үзүүлэлт, 2015, ЭМХТ

2015 онд өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд дунджаар 4.033.4 үзлэг хийгдэж, нэг иргэн жилд дунджаар 2.9 удаа өрхийн эмнэлэгт хандаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авсан байна.

2015 оны байдлаар өрхийн ЭМТ-үүдэд хийгдсэн үзлэгт:

- ✓ Урьдчилан сэргийлэх үзлэг 42.9 хувь,
- ✓ Идэвхтэй хяналтын үзлэг 9.2 хувь,
- ✓ Гэрийн идэвхтэй эргэлт 28.3 хувь ,
- ✓ Амбулаторийн үзлэг 18.8 хувь,
- ✓ Гэрийн дуудлага 0.8 хувийг тус тус эзэлж байна.

Энэ нь өмнөх оны мөн үеэс урьдчилан сэргийлэх үзлэг 0.8 хувиар нэмэгдэж, гэрийн идэвхтэй эргэлтийн үзлэг 0.2 хувиар буурсан байна. “Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт”-д гэрийн идэвхтэй эргэлтийн хувь 30-аас доошгүй байна гэж заасан байдаг.

Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандартад 1800-2000 хүн тутамд 1 их эмч ажиллана гэж заасан хэдий ч 2015 оны байдлаар улсын хэмжээнд 1 өрхийн эмчид 2204 хүн ногдож байхад Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй өрхийн эмнэлгийн 1 эмчид 6484,7 хүн ногдож байна.

Хүснэгт 7.1.1. Өрхийн эрүүл мэндийн төвийн үзүүлэлт, 2006-2015 он

Үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	36.7	37.4	42.16	40.27	40.88	42.57	45.23	42.61	42.16	42.97
Гэрийн идэвхтэй эргэлтийн үзлэгийн хувь	28.1	27.4	30.42	31.22	30.36	30.82	28.91	28.52	28.43	28.27
Идэвхтэй хяналтаас эдгэрэлтийн хувь	43.1	37.8	36.22	39.51	42.08	41.74	36.22	39.51	37,18	29.79


Хүснэгт 7.1.2. Өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, 2015 он

Үзүүлэлт	Өрхийн ЭМТ	Тосгоны ЭМТ	Дүн
Эмнэлгийн тоо	129	5	134
Их эмчийн тоо	622	24	646
Сувилагчийн тоо	577	26	603
Орны тоо	-	74	74
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	-	2790	2790
Дундаж ор хоног	-	6.6	6.6
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	4033462	65788	4099.2
Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	42.97	40.34	42.9
Нэг иргэний жилд үзүүлсэн удаа	2.9	2.2	2.9
Нэг өрхийн эмчид ногдох үзлэгийн тоо	6484.7	2741.1	6345.5
Жирэмсний эрт хяналтын хувь	83.9	82.5	84.0

Тосгоны 5 эрүүл мэндийн төвд 24 их эмч, 26 сувилагч, 6 бусад бага эмч, 5 багийн бага эмч, 3 лаборант нийт 120 ажиллагсад хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Нийт ажиллагсдын 78.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Тосгоны эрүүл мэндийн төвд 9273 өрхийн 29259 хүн ам бүртгэлтэй байна. Жилдээ дунджаар 65.8 мянган үзлэг хийгдэж, нэг иргэн жилд дунджаар 2.2 удаа хандаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авсан байна.


Өрхийн болон тосгоны эрүүл мэндийн төвүүдэд нэг хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтын хувь 93.8 хувь, 1-5 хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтын хувь 95.4 хувь байгаа нь “Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт”-ыг ханган ажилласан байна.

Зураг 7.1.2. Тав хүртэлх насны хүүхдийн хяналт, хувиар, 2005-2015 он



Нэг хүртэлх насны хүүхдийн хяналтын хувь өнгөрсөн оны мөн үеэс 6.2 пунктээр буурсан нь нийслэлд шилжин суурьшигчдын тоо нэмэгдсэн, шилжилт хөдөлгөөн, хаягжилт бүртгэл хангалтгүй байгаатай холбоотой.

Зураг 7.1.3. Хүн амын эрүүл мэндийн индекс, 2006-2015 он



Эрүүл мэндийн индекс буюу нийт хүн амын дунд эзлэх эрүүл хүний хувь 49.7 байгаа нь өмнөх оноос 3 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь эрүүл мэндийн сургалт сурталчилгааны хүртээмж нэмэгдэж, иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилсэн, нөгөө талаар эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь нэмэгдэж байгаатай холбоотой.

7.2. НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Улаанбаатар хотод 8 эрүүл мэндийн төв, 4 нэгдсэн эмнэлэг, 3 амаржих газрууд хүн амд амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Улаанбаатар хотын дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд 795 их эмч, 891 сувилагч, 301 эмнэлгийн дунд мэргэжилтэн нийтдээ 3010 эмнэлгийн ажиллагсад ажиллаж байна.

Хүснэгт 7.2.1. Дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, 2013-2015 он

Үзүүлэлт	2013 он	2014 он	2015 он	Сүүлийн 3 жилийн дундаж
Эмнэлгийн орны тоо	1886	1918	2112	1927
Их эмчийн тоо	796	816	795	802.3
Сувилагчийн тоо	851	856	891	866
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	86404.5	93393	93406	91067.8
Дундаж ор хоног	7.3	7.1	6.9	7.1
Хоног болоогүй нас баралтын хувь	30.25	27.12	30.9	29.42
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	2278191	2334612	2447002	2353268.3
Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	42.5	39.5	39.02	40.34
Багануур, Налайх дүүргийн ЭМТөвд хийгдсэн мэс заслын хагалгаа	1153	3823	5320	3432

Олон улсын жишигт эмч /сувилагчийн харьцаа 1:3 байхаар заасан хэдий ч манай улсад энэ харьцаа хангалтгүй байдаг. Улсын хэмжээнд эмч сувилагчийн харьцаа 1:2 байхад нийслэлийн дүүргүүдийн эмнэлгүүдэд 1:1 байгаа нь ялангуяа хүний нөөцийн бодлого алдагдаж, сувилагчийн хангалтыг хийх шаардлагатай байгааг харуулж байна

Дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн дундаж ор хоног 2014 онд 7.1 байсан бол 2015 онд 6.9 болж 0.2-оор буурч, хэвтэн эмчлүүлэгчдийн тоо өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Эмнэлгийн хоног болоогүй нас баралтын хувь өмнөх оноос 3.7-оор нэмэгдсэн. Амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо 2014 онд 2.3 сая байсан бол 2015 онд 2.4 сая болж нэмэгдсэн нь өвчний учир амбулаторит хандсан хүний тоо нэмэгдсэнтэй холбоотой.

Хүснэгт 7.2.2. Амаржих газруудын тусламж үйлчилгээний үзүүлэлтүүд, 2015 он

Үзүүлэлт	Өргөө амаржих	Хүрээ амаржих	Амгалан амаржих	Бүгд
Эмнэлгийн орны тоо	363	75	120	558
Их эмчийн тоо	106	34	45	185
Сувилагчийн тоо	128	16	38	182
Эх баригч бага эмч	55	39	47	141
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	32838.5	8237.5	10117.5	51193.5
Дундаж ор хоног	3.70	3.74	2.8	3.50
Хоног болоогүй нас баралтын хувь	15.22	7.14	8.33	12.5
Төрөлт	15917	5273	6059	27249
Эхийн эндэгдэл	2	-	1	3
Мэс заслын хагалгаа	12797	2611	1702	17110
Нярайн нас баралт	43	14	11	68

Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй амаржих газруудад нийт 868 ажиллагсад ажиллаж

байна. Нийт эмч нарын 58.3 (n=108) хувийг эх барих, эмэгтэйчүүдийн эмч, 15.6 (n=29) хувийг сэхээн амьдруулах мэдээгүйжүүлэлтийн их эмч, тусгай дунд мэргэжилтний 37.0 (n=141) хувийг эх баригч бага эмч нар тус тус эзэлж байна.


2015 онд амаржих газруудад 27249 эх төрж, 27367 хүүхэд амьд төрсөн байна. Нийт төрөлтийн 0.4 хувийг гэрийн төрөлт эзэлж байна. Амьгүй төрөлтийн түвшин 5.9 хувь, төрөлхийн гажигтай төрсөн нярай 0.5 хувь, бага жинтэй нярайн хувь 2.7 байгаа нь өмнөх оноос амьгүй төрөлтийн түвшин 0.8-аар нэмэгдэж, төрөлхийн гажигтай төрсөн нярайн хувь 0.1, бага жинтэй нярай 0.2 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Нийт 51193.5 хүн эмчлэгдэн 179437 ор хоног ашигласан ба ор ашиглалтын хувь 89.4, дундаж ор хоног 3.5, орны эргэлт 84.2 байна. Эмнэлгийн нас баралтын 72 тохиолдол бүртгэгдсэний 3 тохиолдол нь эхийн эндэгдэл, 68 нь нярайн нас баралт, үүний 63 эрт нярайн эндэгдэл байна. Эмнэлгийн нас баралтын 12.5 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна.

7.3. АМБУЛАТОРИ, ПОЛИКЛИНИКИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

2015 онд НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд дунджаар 8.268,5 сая үзлэг хийгдсэн нь өмнөх оноос 236679 буюу 2.8 хувиар нэмэгджээ.

Зураг 7.3.1. Нийт үзлэг, эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрлөөр, хувиар, 2015 он



Нийт үзлэгийн 48.7 хувийг өрхийн, 0.8 хувийг тосгоны эмчийн үзлэг, 29.5 хувийг дүүргийн эрүүл мэндийн төвүүд, 7.1 хувийг бусад эмнэлгүүд, 13.2 хувийг хувийн эмнэлгийн үзлэг эзэлж байна.

Зураг 7.3.2. Нийт үзлэгийн бүтэц, хувиар, 2015 он




Нийт үзлэгийн бүтцийг авч үзэхэд урьдчилан сэргийлэх үзлэг 36.2 хувийг, гэрийн идэвхтэй үзлэг 13.9 хувийг, гэрийн дуудлагаар 0.5 хувийг, идэвхтэй диспансерийн хяналтын үзлэг 9.6 хувийг, амбулаторийн үзлэг 40.1 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 7.3.1. Амбулаторийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, 2008-2015 он


Үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
10000 хүн амд ногдох нийт ажиллагсад	176.41	174.32	173.33	174.15	175.15	179.74	172.2	175.6
10000 хүн амд ногдох их эмч	43.6	39.8	40.68	41.35	41.1	42.52	43.34	40.88
Эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	65.6	62.5	59.07	59.49	59.01	57.45	57.70	58.38
Жилд нэг иргэний амбулаториор үзүүлсэн дундаж тоо	7.88	7.34	7.01	7.48	6.5	6.37	6.44	6.40
Хүн амын эрүүл мэндийн индекс	44.9	44.9	46.1	47.2	48.4	45.4	46.6	49.7
Нэг их эмчид ногдох хүний тоо	229.35	241.75	245.78	241.84	232.51	235.13	230.71	244.60
Нэг их эмчид ногдох тусгай мэргэжилтэн	1.5	1.57	1.45	1.43	1.28	1.31	1.37	1.42

Улсын хэмжээнд нэг эмчид ногдох хүний тоо 316 байгаа бол нийслэлийн хэмжээнд энэ үзүүлэлт 244.6 байна. Гэсэн хэдий ч 1 өрхийн эмчид ногдож байгаа үзлэг 6484.7 байгаа нь өрхийн эмч дутагдалтай байгааг харуулж байна.

Зураг 7.3.3. Нэг иргэн жилд дунджаар үзүүлсэн удаа, 2006-2015 он



Зураг 7.3.4. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь, 2006-2015 он



Хүснэгт 7.3.2. Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хийгдсэн мэс заслын хагалгааны тоо, 2015 он

Мэс заслын нэр	Мэс засал хийлгэсэн хүний тоо		Үүнээс		Мэс заслын дараах хүндрэл		Нас барсан	
	Бүгд	Үүнээс: 15 хүртэлх насны хүүхэд	Дурангийн мэс засал	Давтан хагалгаа	Бүгд	Үүнээс: 15 хүртэлх насны хүүхэд	Бүгд	Үүнээс: 15 хүртэлх насны хүүхэд
НЭМГ-ын харьяа улсын эмнэлгүүд	68984	13704	129	40	1	0	11	0
НЭМГ-ын харьяа хувийн эмнэлгүүд	19684	3015	76	70	42	28	0	0
ЭХЭМҮТ	14379	7291	235	0	34	13	0	0
УНТЭ	10200	33	1820	19	19	0	32	0
УХТЭ	2174	0	907	16	25	0	9	0
УГТЭ	5867	0	0	16	20	1	15	0
ГССҮТ	8174	1697	143	5	4	0	147	18
ХСҮТ	2149	10	96	8	7	0	28	0
ХӨСҮТ	553	34	0	41	0	0	0	0
ЭМСЯ-ны харьяа тусгай зөвшөөрөл бүхий хувийн эмнэлгүүд	7749	503	1110	106	13	0	6	0
БҮГД	139922	26287	4516	321	165	42	248	18

7.4. ХУВИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ


Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байгууллагын чиг үүрэгт хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нь хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг төрөлжсөн клиникийн хэлбэрээр үзүүлнэ гэж заасан байдаг. (Эрүүл мэндийн тухай хууль)

Монгол улсад хувийн эмнэлгийн тогтолцоо бүрдсэнээс хойш өнөөг хүртэл хотод 993, аймагт 237 хувийн хэвшлийн ЭМБ тусламж үйлчилгээ үзүүлж байна.


Улаанбаатар хотод 2015 оны байдлаар нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа ор бүхий 87 эмнэлэг, 89 сувилал, 817 амбулаторийн тусламж үйлчилгээ үзүүлсэн ба нийт 993 эмнэлгүүдэд 1811 их эмч, 1489 эмнэлгийн тусгай дунд мэргэжилтэн үүнээс 1069 сувилагч, нийт 4940 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна.

2015 онд НЭМГ-ын харьяа хувийн эмнэлгүүд 1094273 амбулаторийн үзлэг хийсэн ба өмнөх оноос 62698-аар нэмэгдсэн байна.

Амбулаторийн үзлэгийн 2.9 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 96.5 хувийг өвчний учир амбулаторийн үзлэг, 0.5 хувийг идэвхтэй хяналтын үзлэг, 0.1 хувийг гэрийн эргэлт, гэрийн дуудлага эзэлж байна.

Зураг 7.4.1. Амбулаторийн үзлэг кабинетаар, хувиар, 2015 он

Нийт үзлэгийн 43 хувийг шүд, 17 хувийг эмэгтэйчүүд, 11 хувийг дотор, 7 хувийг уламжлалт, 6 хувийг нүд, 5 хувийг хүүхдийн эмнэлгийн үзлэг тус тус эзэлж байна.

Зураг 7.4.2. Амбулаторийн үзлэг насны ангиллаар, хувиар, 2015 он


Хувийн хэвшлийн ор бүхий эмнэлгүүдийн тусламж үйлчилгээ:

Ор бүхий эмнэлгүүдэд 54102.5 хүн эмчлэгдэн гарсан нь өмнөх оноос хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 4270.5 буюу 7.8 хувиар нэмэгдсэн ба дундаж ор хоног 6.8, орны эргэлт 25.3, орны фонд ашиглалтын хувь 56.7 байна.

Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа хувийн эмнэлэгт 270 эх төрж, 272 хүүхэд амьд төрсөн байна.

Ортой эмнэлгүүдийн 80.9% нь дотор, уламжлалт, эмэгтэйчүүд, мэдрэлийн нарийн мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 7.4.3. Ор бүхий хувийн эмнэлгүүдийн эмчлэгдсэн хүний тоо, тасгаар, 2015 он




7.5. ЯАРАЛТАЙ ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



Түргэн тусламжийн үйлчилгээг үр дүнтэй бүтэц, зохион байгуулалтад оруулах, менежментийг сайжруулах, техник, багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, боловсон хүчний мэдлэг, чадварыг дээшлүүлэх замаар олон улсын жишигт ойртсон нэгдсэн тогтолцоо бий болгох шаардлагын үүднээс “Үндэсний түргэн тусламжийн сүлжээ хөтөлбөр”-ийг 2010 оны 12 сарын 08-ны өдрийн Засгийн газрын тогтоолоор баталсан.

Нийслэлд 2012-2013 онуудад Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдэд, 2014 онд Хан Уул дүүрэгт яаралтай түргэн тусламжийн салбар пунктуудыг шинээр нээж, Улаанбаатар хотын түргэн тусламжийн үйлчилгээний хүртээмж, шуурхай байдлыг хангах зорилгоор нийслэлийн түргэн тусламжийн төвд 22, дүүргүүдийн түргэн тусламжийн төвүүдэд 7 зориулалтын, тоноглол бүхий авто машиныг нийлүүлээд байна.

2015 оны байдлаар 383679 дуудлага хүлээн авч үйлчилсэн ба өмнөх оноос 17647 буюу 4.5 хувиар нэмэгдсэн, үүнээс алсын дуудлага 0.02 хувийг эзэлж байна. Нийт дуудлагын дотор дүүргүүдийн хүүхдийн түргэн тусламжийн дуудлага 17.8 хувийг эзэлж байна.

Зураг 7.5.1. Дуудлагын төрлөөр, бодит тоогоор, 2012-2015 он



Зураг 7.5.2. Хүний нөөц, бодит тоогоор, 2013-2015 он**Зураг 7.5.3.** Дуудлагын төрөл, хувиар, 2013-2015 он

2015 онд нийт дуудлагын 71.8 хувийг гэнэтийн өвчлөлийн, 8.4 хувийг төрөхийн, 15.7 хувийг осол гэмтлийн дуудлага эзэлж байна. Осол гэмтлийн дуудлага сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Осол гэмтлийн дуудлагын 10.4 хувь нь гудамжны, 6.0 хувь нь зам тээврийн осол, 0.7 хувь нь амиа хорлосон, 4.6 хувь нь бусдад хорлогдсон, 1.2 хувь нь үйлдвэрийн осол, 0.2 хувь нь спортын, 26.4 хувь нь архины хордлогын, 50.4 хувийг бусад осол тус тус эзэлж байна.

Зураг 7.5.4. Осол гэмтлийн дуудлагын төрөл, хувиар, 2014-2015 он


7.6. НАСТНЫ ЭРҮҮЛ МЭНД

Нийслэлд нийт 99.3 мянган настан амьдарч байгаагаас 39.2 мянга буюу 39.5 хувь нь эмчийн хяналтанд байна. Энэ онд 7164 настанг шинээр хяналтанд авсан байна. Нийт настны 35.3 мянга буюу 90.0 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан ба, 12.7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй байна. Өвчлөлийн байдлаар 1180 буюу 1.2 хувь нь сэтгэцийн болон зан төрхийн эмгэгтэй, насны доройтолтой 1130 буюу 1.1 хувийг эзэлж байна.


Настангуудын өдөр тутмын бие даах чадвар 77.8 хувьд нь, багаж хэрэгсэлтэй ажиллах чадвар 75.9 хувьд нь, сэтгэц танин мэдэхүйн чадвар 78.3 хувьд нь хэвийн байна.

7.7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Улсын хэмжээнд 100.1 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаагаас нийслэлд 33.6 мянга нь байна. Үүний 52.2 хувь нь эрэгтэй 47.8 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна.


Зураг 7.7.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд насны бүлгээр, хувиар, 2015 он

Зураг 7.7.2. Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрүүд, насны бүлгээр, 2015 он




Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 63.2 хувь нь 30-59 насны хүмүүс эзэлж байгаа нь анхаарал татаж байна.

Зураг 7.7.3. Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрүүд, хувиар, 2015 он




Хөгжлийн бэрхшээлтэй хүний хяналтын мэдээллээр 7921 буюу 23.5 хувь нь төрөлхийн, 25732 буюу 76.4 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байна.

Зураг 7.7.4. Хөгжлийн бэрхшээлийн төрөл, бодит тоогоор, 2015 он



Олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 18.0 мянга буюу 78.1% нь өвчнөөр, 5.0 мянга буюу 21.8% нь осол гэмтлээр хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Зураг 7.7.5. Осол гэмтлийн шалтгаант хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, 2015 он

Өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэдийн 4.3 хувийг мэргэжлээс шалтгаалах өвчин, 95.6 хувь нь ердийн өвчин эзэлж байна. Осол гэмтлүүдийн дотор зам тээврийн осол 28.7 хувь, ахуйн осол 29.0 хувь, үйлдвэрийн осол 10.6 хувь, бусад осол 31.5 хувийг тус тус эзэлж байна.

2015 оны тайлангаар нийслэлд 5745 хүн протези хийлгэсэн ба 954 хүн тэргэнцэртэй, байнгын асаргаанд 5045 хүн байна. 15 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзвэл улсын хэмжээнд хөдөлмөр эрхэлдэг иргэдийн хувь 22 байгаа бол нийслэлд 18.1 хувь, хөдөлмөр эрхэлдэггүй иргэд улсын хэмжээнд 77.9 хувь, нийслэлд 81.8 хувь байна.

7.8. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Нийслэлийн хэмжээнд 88 сэтгэцийн эмч эрүүл мэндийн туслаж үйлчилгээ үзүүлж байгаагаас дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд 13 буюу 14.7 хувь, төрөлжсөн төв эмнэлэгт 62 буюу 70.4 хувь, хувийн эмнэлгүүдэд 4 буюу 4.5 хувь, бусад эмнэлэгт 8 буюу 9.0 хувь нь ажиллаж байна.

НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд 44390 үзлэг хийгдсэнээс дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд 43553 буюу 98.1 хувь, бусад эмнэлэгт 837 буюу 1.8 хувийг тус тус эзэлж байна.


2015 оны байдлаар нийслэлд сэтгэцийн эмгэгээр 14007 өвчлөл бүртгэгдсэн ба 10000 хүн амд 108.5 байна. Сэтгэцийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан 10000 хүн амд харьцуулснаар

✓ Сэтгэц идэвхт эм, бодисын шалтгаант сэтгэцийн ба зан төрхийн эмгэгүүд	42.8
✓ Сэтгэцийн органик ба шинж тэмдгийн эмгэг	36.8
✓ Стресстэй холбоотой, невротын эмгэгүүд	33.4
✓ Шизофрени, шизофренийн хэв шинжит ба дэмийрэх эмгэгүүд	31.9
✓ Оюуны хомсдол	11.5

Сэтгэц идэвхт эм, бодисын шалтгаант сэтгэцийн ба зан төрхийн эмгэгүүдийн 98.3 хувийг архины шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд, 0.5 хувийг тамхины шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд, 0.1 хувийг тайвшруулах, нойрны эмийн шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд эзэлж байна.

Сэтгэцийн органик ба шинж тэмдгийн эмгэгүүдийн дотор тархины өвчин, гэмтлийн улмаас үүссэн сэтгэцийн эмгэг дийлэнх хувийг эзэлж байна. Оюуны хүндэвтэр хомсдол 40.7 хувь, хөнгөн 51.2 хувь, хүнд хомсдол 8 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 7.8.1. Сэтгэцийн ба зан төрхийн эмгэг, дүүргээр, 10000 хүн амд, 2015 он



Бүлэг VIII. НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ХҮНИЙ НӨӨЦ

Эрүүл мэндийн салбарт 2015 онд улсын болон хувийн хэвшлийн нийт эрүүл мэндийн байгууллагууд болон бусад салбарын эрүүл мэндийн ажиллагсад нийт 47249 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 2.9 хувиар өссөн байна. Нийт ажиллагсдаас 93.2 хувь нь эрүүл мэндийн салбарын, 6.8 хувь нь бусад салбарын эрүүл мэндийн ажиллагсад эзэлж байна. Эрүүл мэндийн нийт ажиллагсдаас 9.5 мянга нь их эмч, 1.5 мянга нь эм зүйч, 11.3 мянга нь сувилагч, 7.4 мянга нь эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан байна. ⁵

Хүснэгт 8.1. Эрүүл мэндийн салбарын эмч ажиллагсдын үзүүлэлт, 2015 он

Үзүүлэлт		Улсын хэмжээнд	Улаанбаатарт
Их эмч	Бодит тоо	9563	5277
	10000 хүн амд	31.3	40.9
Сувилагч	Бодит тоо	11357	5273
	10000 хүн амд	37.1	40.8
Эх баригч	Бодит тоо	916	252
	10000 хүн амд	0.3	1.9
Нийт ажиллагсад	Бодит тоо	47429	22664
	10000 хүн амд	155.1	175.6

Нийслэлийн эрүүл мэндийн салбарт 22664 хүн ажиллаж байгаагаас удирдах ажилтан 644, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн 561, үүнээс статистик их эмч 56, мэдээлэл технологийн инженер 113, их эмч 5277, эм зүйч 983, бусад дээд мэргэжилтэн 1912, эмнэлгийн тусгай мэргэжлийн мэргэжилтэн 7535 байгаагаас сувилагч 5273, эм найруулагч 755, бага эмч 255, үүний 5 нь багийн бага эмч, техникч 326, лаборант 443, эх баригч 252 тус тус ажиллаж байна.

Нийт ажиллагсдын 7.9 хувь нь өрх, тосгоны эрүүл мэндийн төв, 13.2 хувь нь дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, 25.5 хувь нь төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, 32.7 хувь нь хувийн эмнэлэг, эмийн сангууд, 9.8 хувь нь амаржих газар болон бусад эрүүл мэндийн байгууллагуудад, бусад салбарын эрүүл мэндийн байгууллагуудад 10.6 хувь нь ажиллаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Нийт ажиллагсдын 82.67 хувь нь эмэгтэй, 0.1 хувь нь 20-иос доош, 26.17 хувь нь 20-29 нас, 26.35 хувь нь 30-39 насны, 27.32 хувь нь 40-49 насны, 11.93 хувь нь 50-54 насны, 5.7 хувь нь 55-60 насны, 2.3 хувь нь 60-аас дээш насныхан эзэлж байна.

Улсын хэмжээнд нэг эмчид ногдох хүний тоо 2015 онд 316 байгаа нь өмнөх оноос 2 хүнээр, нэг сувилагчид ногдох хүний тоо 267 болж, өмнөх оноос 4 хүнээр тус тус буурсан байна.

⁵ Эрүүл мэндийн үзүүлэлт, 2015, ЭМХТ

Улаанбаатар хотод нэг эмчид ногдох хүний тоо 237, нэг сувилагчид ногдох хүний тоо 234 байна. 10000 хүн амд их эмч 40.8, тусгай мэргэжлийн мэргэжилтэн 58.4, эрүүл мэндийн нийт ажиллагсад 175.6 ногдож байгаа нь өмнөх онтой харьцуулахад их эмч 2.4, нийт ажиллагсад 2.6, эмнэлгийн тусгай мэргэжлийн мэргэжилтэн 1.2-оор тус тус буурсан байна.


Нийслэлд 2015 оны байдлаар улсын болон хувийн хэвшлийн 1492 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Нийт их эмч нарын 7.5 хувийг уламжлалт анагаахын, 14.0 хувийг нүүр амны их эмч, 78.6 хувийг бусад мэргэжлийн их эмч тус тус эзэлж байгаа бөгөөд хүний их эмч нарын 19.5 хувь нь ерөнхий мэргэжлийн, 80.4 хувь нь үндсэн ба төрөлжсөн мэргэжлийн эмч нар байна. Үндсэн ба төрөлжсөн мэргэжлийн эмч нарын 17.7 хувь нь дотор, 9.3 хувь нь хүүхэд, 7.8 хувь нь дүрс оношлогоо, 5.9 хувь нь лаборатори, 6.4 хувь нь мэс засал, 5.4 хувь нь мэдрэл, 4.3 хувь нь мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний эмч нар эзэлж байна.

2015 оны байдлаар нийслэлийн хэмжээнд мэргэжлийн зэрэгтэй 2860 эмч мэргэжилтэн байгаа нь нийт эмч мэргэжилтнүүдийн 13.0 хувь, боловсролын зэрэгтэй 1362 эмч мэргэжилтнүүд байгаа нь 6.0 хувийг тус тус эзэлж байна. Мэргэжлийн зэргийн дийлэнх хувийг ахлах, боловсролын зэргийн дийлэнхийг магистрын зэрэг эзэлж байна.

Эрүүл мэндийн салбарын нийт их эмч нарын 22.1 хувь нь ахлах, 12.9 хувь нь тэргүүлэх зэрэгтэй, 24.8 хувь нь магистр, 2.5 хувь нь анагаах ухааны доктор, 0.5 хувийг доктор эзэлж байна. Эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн 15.1 хувь ахлах зэрэгтэй, 4.1 хувь нь тэргүүлэх зэрэгтэй, 0.2 хувь нь магистрын зэрэгтэй эмнэлгийн дунд мэргэжилтнүүд ажиллаж байна.


Зураг 8.1. 10000 хүн амд ногдох эмнэлгийн ажиллагсад, их эмч, тусгай мэргэжилтэн, 2006-2015 он



Бүлэг IX. НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нийслэлийн эрүүл мэндийн салбарын 2006-2015 оны санхүүжилтийн үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлээр танилцуулж байна.


Зураг 9.1. Нийслэлийн эрүүл мэндийн салбарын санхүүжилт, тэрбум төгрөгөөр, 2006-2015 он



